



Монгол Улс, Улаанбаатар,
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,
Гэндэнгийн гудамж, Ардчиллын
Өргөө, 6 давхар
Утас: 77118193; 77118194

Бүдрагчаагийн Баяр
Гүйцэтгэх захирал
Mobile: 88105991
bayar@elclawoffice.mn;
Вэбсайт: www.elclawoffice.mn

2018 оны 3-р сарын 9-ний өдөр

ЭРДЭНЭ РЕСОРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРЭЙШН

Канад Улс В3А 4S5
Нова Скотиа, Дартмоут
99 Вис Роуд, Метрополитан Плэйс
1480 тоот

МӨН

БИДИСЕК ҮЦК ХХК

Монгол Улс, Улаанбаатар хот,
Залуучуудын Өргөн Чөлөө-27/1
Сүхбаатар дүүрэг, 8-р хороо

Эрдэнэ Ресорс Девелопмент Корпорэйшний Монголын Хөрөнгийн Биржид гаргах энгийн хувьцааны давхар бүртгэлд зориулсан хууль зүйн дүгнэлт

Эрхэм хүндэт танаа,

Канад улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан, Торонтогийн Хөрөнгийн Бирж (**ТХБ**)-д бүртгэлтэй компани болох **ЭРДЭНЭ РЕСОРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРЭЙШН (ЭРД)** нь өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх зорилгоор гурван (4) сая ширхэг хүртэл энгийн хувьцааг (**Энгийн хувьцаа**) Монгол Улсад үнэт цаасны танилцуулга (**Танилцуулга**)-д тусгасан нөхцөл болон Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу нээлттэй санал болгохоор (**Санал болгох ажиллагаа**) шийдвэрлээд байна.

ЭРД-ийн Энгийн хувьцааг Монголын Хөрөнгийн Бирж (**МХБ**)-д гаргаж, үнэт цаасны давхар бүртгэл (**Бүртгэл**)-ийг хийлгэхээр өргөдөл гаргаж байгаатай холбоотойгоор тус Өмгөөллийн ИЭлСи ХХН (**ИЭлСи**) нь үнэт цаас гаргагчийн хуулийн зөвлөхөөр ажиллалаа¹.

Хууль зүйн дүгнэлтийн цар хүрээ

Хууль зүйн салбарт 18 жил үйл ажиллагаа явуулсан туршлага дээрээ үндэслэн, мөн үнэт цаасны зах зээлд оролцогчдод зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх эрхтэй өмгөөллийн нөхөрлөлийн хувьд² бид 2013 оны 5-р сарын 24-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Монгол Улсын Үнэт Цаасны Зах Зээлийн тухай хууль (**Үнэт цаасны хууль**)-ийн 10 дугаар зүйлийн 10.6, Монгол Улсын Санхүүгийн Зохицуулах Хороо (**СЗХ**)-ноос 2018 оны 1-р сарын 10-ны өдрийн 19 тоот Тогтоолоор баталсан “Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд Монгол Улсад үнэт цаас гаргах, Монгол Улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд гадаад улсад гаргах үнэт цаасыг бүртгэх журам” (**СЗХ Журам**)-ын 3 дугаар зүйлийн 3.3.7 болон МХБ-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2018 оны 1-р сарын 25-ны өдрийн 2018/01 тоот Тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны бүртгэлийн журам” (**МХБ Журам**)-ын 4 дугаар зүйлийн 4.5-д заасны дагуу энэхүү хууль зүйн дүгнэлт (**Дүгнэлт**)-ийг ЭРД болон түүний Монгол Улсад бүртгэлтэй охин компаниуд, тодруулбал Эрдэнэ Монгол ХХК (**ЭМ**), Аниан Ресорсиз ХХК (**АР**) болон Лидер Эксплорэйшн ХХК (**ЛЭ**)-иудын хувьд гаргаж байна.

ИЭлСи нь Канад улсын хууль тогтоомжийн талаар зөвлөгөө өгөх эрхгүй тул ЭРД-ийн эрх зүйн байдал, эрх бүхий этгээдүүдийн бүрэн эрх, томоохон гэрээ, хэлцэл болон Канад улсын хуулиар тодорхойлогдох бусад асуудалд Канад улсын хуулийн фирм болох МакИннес Күүперийн дүгнэлт (**Канадын дүгнэлт**)-ийг авч, энэхүү Дүгнэлтийн 1-р Хавсралт болгон оруулсан болно.

Уг Дүгнэлтийг 2018 оны 1-р сарын 25-ны өдрөөс 3-р сарын 9-ний өдрийн хооронд ИЭлСи-д ирүүлсэн мэдээлэлд үндэслэн гаргав. ИЭлСи нь Дүгнэлтийг 2018 оны 3-р сарын 9-ний өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу боловсруулав. Бусад орны хууль тогтоомжийн дагуу ямар нэг дүгнэлт гаргаагүй болно.

Бид санхүү, нягтлан бодох бүртгэл, худалдаа зэрэг татварын болон бусад тусгайлсан ур чадвар, мэргэшил шаардах аливаа асуудлаар мөн дүгнэлт гаргаагүй болно.

¹ИЭлСи болон ЭРД-ийн Монгол дахь охин компани болох ЭМ-ын хооронд 2018 оны 1-р сарын 24-ний өдөр ЭРД-ийн давхар бүртгэлийн асуудлаар Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулсан. Гэрээний дагуу ИЭлСи нь үнэт цаасны бүртгэлийн журмын дагуу шаардаж буй хууль зүйн дүгнэлтийг ЭРД болон түүний Монгол дахь компаниудад гаргах, ЭРД-ийн Үнэт цаасны танилцуулгад тусгах Монгол болон Канад улсын үнэт цаасны хууль тогтоомжийн зөрүүтэй байдлын талаарх мэлээллийг бэлтгэх, мөн бүртгэлийн ажиллагааны явцад шаардлагатай хууль зүйн зөвлөгөөг өгөх зэрэг үйлчилгээг үзүүлэн ажиллана.

² ИЭлСи нь СЗХ-ны 2014 оны 1-р сарын 29-ны өдрийн 24 тоот Тогтоолоор үнэт цаасны зах зээлд оролцогч этгээдүүдэд зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх эрхтэй этгээдээр зөвшөөрөгдсөн. Тогтоолын хуулбарыг энэхүү Дүгнэлтийн 5-р Хавсралтад оруулав.

Дүгнэлтийн хураангуй

Дор дурдсан мэдээлэл болон өөрсдийн шаардлагатай гэж үзсэн хяналт, шалгалтын материалд үндэслэн, энд тодорхойлсон хязгаарлалт болон нөхцөлийн хүрээнд бид дараах дүгнэлтийг гаргаж байна:

ЭРД болон түүний Монгол Улсад бүртгэлтэй компаниуд нь харьяалсан улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдаж, хууль ёсоор бүртгэгдсэн байна.

1. ЭРД нь Канад улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан, албан ёсны бүртгэлтэй хуулийн этгээд бөгөөд 2004 онд өөрийн улсын холбогдох үнэт цаасны хууль тогтоомжийн дагуу ТХБ-ийн Гарааны бизнес санхүүжүүлэх төвд бүртгүүлэн, олон нийтийн компани болсон (TSXV: ERD). 2005 оны 12-р сард ТХБ-ийн үндсэн ангилалд (TSX: ERD) нэрээр байршсан байна. Сүүлд 2013 оны 4-р сарын 18-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан ЭРД-ийн Дүрэм (**ЭРД-ийн Дүрэм**) нь Канадын Бизнесийн байгууллагын хуульд нийцсэн болно³.
2. ЭРД нь одоогийн явуулж буй үйл ажиллагаагаа эрхлэх хуулийн этгээдийн эрх хэмжээтэй, аливаа гуравдагч этгээдтэй гэрээ, хэлцэл байгуулах эрхтэй, шүүхийн хэрэг, маргаанд өөрийн нэрийн өмнөөс оролцох эрх зүйн чадвартай хуулийн этгээд юм.
3. ЭРД нь хязгааргүй тооны зарласан хувьцааг гаргах эрхтэй. 2018 оны 2-р сарын 28-ны өдрийн байдлаар нийт 146'400'586 ширхэг Энгийн хувьцааг хувьцаа эзэмшигчдэд эзэмшүүлсэн, нийт 9'316'250 ширхэг Урамшуулалт хувьцааны опцион, 3'410'186 ширхэг Ирээдүйд эзэмшүүлэх нэгж хувьцаа, мөн 1'075'324 ширхэг Нөхөн төлбөрийн опцион гаргаад байна. Хувьцаа болон опцион нь хүчин төгөлдөр бөгөөд тэдгээрийг гаргахад шаардлагатай бүхий л арга хэмжээг авсан байна.
4. ЭРД-ийн зүгээс гаргасан хувьцааг нь 100 хувь эзэмшдэг ЭМ нь Монгол Улсын хуулийн дагуу 2005 оны 12-р сарын 8-ны өдөр хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр үүсгэн байгуулагдсан, Монгол Улсын хуулийн этгээд бөгөөд 2718243 тоот регистрийн дугаартайгаар үйл ажиллагаа явуулдаг. ЭМ нь одоогийн явуулж буй үйл ажиллагаагаа эрхлэх хуулийн этгээдийн эрх хэмжээтэй, аливаа гуравдагч этгээдтэй гэрээ, хэлцэл байгуулах эрхтэй, шүүхийн хэрэг, маргаанд өөрийн нэрийн өмнөөс оролцох эрх зүйн чадвартай хуулийн этгээд юм. ЭМ-ын хамгийн сүүлд нэмэлт, өөрчлөлт орсон Дүрэм (**ЭМ-ын Дүрэм**)-г 2016 оны 12-р сарын 15-ны өдөр Монгол Улсын Оюуны Өмч, Бүртгэлийн Ерөнхий Газрын Хуулийн Этгээдийн Бүртгэлийн Газар (**ХЭБГ**)-т бүртгүүлсэн байх бөгөөд ЭМ-ын Дүрэм нь Монгол Улсын Компанийн тухай хууль (**Компанийн хууль**)-ийн шаардлагад нийцсэн байна.
5. ХЭБГ-т бүртгэгдсэн мэдээллийн дагуу ЭМ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 149'263'000 (*нэг зуун дөчин есөн сая хоёр зуун жаран гурван мянга*)

³1, 2 болон 3-р хэсгийн дүгнэлтийг Канадын Дүгнэлтийн "Дүгнэлт" хэсгийн 1-ээс 5-р хэсгээс баталгаажуулж болно.

төгрөг бөгөөд нэгж хувьцааны нэрлэсэн үнэ нь 1'000 (*нэг мянга*) төгрөг байна. Нийт хувьцаанд хамаарах хөрөнгийг ЭРД-ээс бүрэн оруулсан байна.

6. ЭРД-ийн зүгээс хувьцааг нь 100 хувь эзэмшдэг АР нь Монгол Улсын хуулийн дагуу 2005 оны 12-р сарын 7-ны өдөр хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр үүсгэн байгуулагдсан Монгол Улсын хуулийн этгээд бөгөөд 2874229 тоот регистрийн дугаартайгаар үйл ажиллагаа явуулдаг. АР нь одоогийн явуулж буй үйл ажиллагаагаа эрхлэх хуулийн этгээдийн эрх хэмжээтэй, аливаа гуравдагч этгээдтэй гэрээ, хэлцэл байгуулах эрхтэй, шүүхийн хэрэг, маргаанд өөрийн нэрийн өмнөөс оролцох эрх зүйн чадвартай хуулийн этгээд юм. АР-ын хамгийн сүүлд нэмэлт, өөрчлөлт орсон Дүрэм (*АР-ын Дүрэм*)-г 2016 оны 12-р сарын 15-ны өдөр ХЭБГ-т бүртгүүлсэн байх бөгөөд Компанийн тухай хуулийн шаардлагад нийцсэн байна.
7. ХЭБГ-т бүртгэгдсэн мэдээллийн дагуу АР-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 648'204'000 (*зургаан зуун дөчин найман сая хоёр зуун дөрвөн мянга*) төгрөг бөгөөд нэгж хувьцааны нэрлэсэн үнэ нь 12'000 (*арван хоёр мянга*) төгрөг байна. Нийт хувьцаанд хамаарах хөрөнгийг ЭРД-ээс бүрэн оруулсан байна.
8. ЭМ-ын зүгээс нийт гаргасан хувьцааных нь 51 хувийг эзэмшдэг ЛЭ нь Монгол Улсын хуулийн дагуу 2017 оны 5-р сарын 8-ны өдөр хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр үүсгэн байгуулагдсан Монгол Улсын хуулийн этгээд бөгөөд 6183077 тоот регистрийн дугаартайгаар үйл ажиллагаа явуулдаг. ЭМ нь ЛЭ-ийн хувьцааг Монгол Улсын иргэн Загдрагчаагийн Эрдэнэчулууны хамтаар эзэмшдэг бөгөөд З.Эрдэнэчулуун нь ЛЭ-ийн 49 хувийн хувьцаа эзэмшигч юм. ЛЭ нь одоогийн явуулж буй үйл ажиллагаагаа эрхлэх хуулийн этгээдийн эрх хэмжээтэй, аливаа гуравдагч этгээдтэй гэрээ, хэлцэл байгуулах эрхтэй, шүүхийн хэрэг, маргаанд өөрийн нэрийн өмнөөс оролцох эрх зүйн чадвартай хуулийн этгээд юм. ЛЭ-ийн хамгийн сүүлд нэмэлт, өөрчлөлт орсон Дүрэм (*ЛЭ-ийн Дүрэм*)-г 2017 оны 8-р сарын 23-ны өдөр ХЭБГ-т бүртгүүлсэн байх бөгөөд Компанийн тухай хуулийн шаардлагад нийцсэн байна.
9. ХЭБГ-т бүртгэгдсэн мэдээллийн дагуу ЛЭ-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 100'000 (*нэг зуун мянга*) төгрөг бөгөөд нэгж хувьцааны нэрлэсэн үнэ нь 1'000 (*нэг мянга*) төгрөг байна. Нийт хувьцаанд хамаарах хөрөнгийг ЭРД болон З.Эрдэнэчулуунаас бүрэн оруулсан байна.

ЭРД болон түүний Монгол компаниудын төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтны бүрэн эрх нь хүчин төгөлдөр байна.

10. ЭРД нь найман (8) эрх бүхий захирлаас бүрдсэн Захирлуудын Зөвлөлийг томилон ажиллуулдаг. Захирлуудыг 2017 оны 6-р сарын 14-ны өдөр хуралдсан Хувьцаа эзэмшигчдийн жилийн, ээлжит бус хурлаар томилсон бөгөөд Захирлуудын Зөвлөл нь өөрт олгогдсон эрх, үүргийг хэрэгжүүлэх бүрэн эрх хэмжээтэй байна⁴.

⁴10, 11 болон 12-р хэсгийн дүгнэлтийг Канадын Дүгнэлтийн "Дүгнэлт" хэсгийн 10 болон 11-р хэсгээс баталгаажуулж болно.

11. Захирлуудын хэнд ч үнэт цаасны хууль тогтоомжтой холбоотойгоор харьяалсан улсын шүүхээс эсвэл үнэт цаасны зохицуулагч байгууллагаас ямар нэг шийтгэл оногдуулаагүй, албадлагын арга хэмжээ аваагүй, үнэт цаасны зохицуулагч байгууллагатай төлбөр тооцооны гэрээ хийгээгүй; мөн хөрөнгө оруулагчаас үнэт цаасны арилжаатай холбоотой гаргах шийдвэрт нөлөөлөх ямар нэг шийтгэл болон торгууль оногдуулаагүй болно.
12. ЭРД-ийн Ерөнхийлөгч бөгөөд Гүйцэтгэх захирал нь Петер С. Акерли бөгөөд тэрээр мөн ЭРД-ийн Захирлуудын Зөвлөлийн гишүүн юм. Түүнийг 2017 оны 6-р сарын 14-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн жилийн, ээлжит бус хурлаар томилсон байна.
13. ЭМ нь гурван (3) гишүүнээс бүрдэх Төлөөлөн Удирдах Зөвлөлтэй байхаар өөрийн Дүрэмдээ тусгасан бөгөөд гишүүд нь хувьцаа эзэмшигч ЭРД-ийн 2017 оны 5-р сарын 7-ны өдрийн шийдвэрээр томилогдсон, бүрэн эрх нь хүчин төгөлдөр, ЭМ-ын Дүрэм болон Компанийн хуулийн дагуу олгогдсон эрх, үүргийг хэрэгжүүлэх бүрэн эрх хэмжээтэй байна.
14. ЭРД-ийн Ерөнхийлөгч бөгөөд Гүйцэтгэх захирал Петер С. Акерли нь ЭМ-ын гүйцэтгэх удирдлагыг өөрөө хэрэгжүүлдэг бөгөөд ХЭБГ-т ЭМ-ын Гүйцэтгэх захирлаар албан ёсоор бүртгэгдсэн байна. Тэрээр ЭМ-ын Дүрэм болон Компанийн хуулийн дагуу өөрт олгогдсон эрх, үүргийг хэрэгжүүлэх бүрэн эрх хэмжээтэй байна.
15. АР нь гурван (3) гишүүнээс бүрдэх Төлөөлөн Удирдах Зөвлөлтэй байхаар өөрийн Дүрэмдээ тусгасан бөгөөд гишүүд нь хувьцаа эзэмшигч ЭРД-ийн 2017 оны 5-р сарын 7-ны өдрийн шийдвэрээр томилогдсон, гишүүдийн бүрэн эрх нь хүчин төгөлдөр, АР-ын Дүрэм болон Компанийн хуулийн дагуу олгогдсон эрх, үүргийг хэрэгжүүлэх бүрэн эрх хэмжээтэй байна.
16. ЭРД-ийн Ерөнхийлөгч бөгөөд Гүйцэтгэх захирал Петер С. Акерли нь АР-ын гүйцэтгэх удирдлагыг өөрөө хэрэгжүүлдэг бөгөөд ХЭБГ-т АР-ын Гүйцэтгэх захирлаар албан ёсоор бүртгэгдсэн байна. Тэрээр АР-ын Дүрэм болон Компанийн хуулийн дагуу өөрт олгогдсон эрх, үүргийг хэрэгжүүлэх бүрэн эрх хэмжээтэй байна.
17. ЛЭ нь таван (5) гишүүнээс бүрдсэн хувьцаа эзэмшигчдэд зөвлөх Зөвлөлийг 2017 оны 8-р сарын 18-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас томилсон байна. Таван гишүүн нь хувьцаа эзэмшигчдээс болон ЛЭ-ийн Дүрмээр тэдгээрт олгогдсон эрх, үүргийг хэрэгжүүлэх эрх хэмжээтэй байна.
18. 2017 оны 8-р сарын 18-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас Монгол Улсын иргэн Анхбаярын Билгүүнийг ЛЭ-ийн Гүйцэтгэх захирлаар томилсон бөгөөд ХЭБГ-т зохих бүртгэлийг хийлгэсэн байна. Тэрээр ЛЭ-ийн Дүрэм болон Компанийн хуулийн дагуу өөрт олгогдсон эрх, үүргийг хэрэгжүүлэх бүрэн эрх хэмжээтэй байна.

ЭРД болон түүний Монгол дахь компаниудын сүүлийн нэг (1) жилийн дотор хийсэн томоохон хэлцлүүд нь холбогдох хууль тогтоомжийн дагуу хийгдсэн байна.

19. ЭРД нь сүүлийн нэг жилийн хугацаанд томоохон хоёр (2) гэрээг байгуулсан байна. Тэдгээр нь 2017 оны 3-р сарын 21-ний өдөр хийсэн Тек Ресурс Лимитэд компанитай байгуулсан Хаалттай хүрээнд хөрөнгө татан төвлөрүүлэх хэлцэл (Private Placement), мөн 2016 оны 3-р сарын 18-ны өдөр Сандсторм Гоулд Лимитэд компанитай хийсэн Хувьцаа захиалгын гэрээ юм. Хувьцаа захиалгын гэрээний хувьд хэдийгээр 2016 онд хийгдсэн боловч гэрээний дагуу захиалгын хүчин төгөлдөр байх хугацаа нь 2017 оны 10-р сар хүртэл үргэлжилсэн болно. Дээрх гэрээг байгуулахтай холбоотойгоор ЭРД-ээс зохих шийдвэр, тогтоолыг гаргасан, гэрээнүүд нь хүчин төгөлдөр болно⁵.
20. ЭМ нь 2017 онд ямар нэг их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгээгүй байна. Харин 2017 оны 8-р сард ЛЭ-ийн 51 хувийн хувьцааг худалдан авах хэлцэл байгуулсан байна. Хэлцлийн дагуу ЭМ нь 2017 оны 8-р сарын 18-нд Загдрагчаагийн Эрдэнэчулуун болон Загдрагчаагийн Эрдэнэхуяг нарын хамтаар Хувьцаа худалдах, худалдан авах гэрээ, мөн З.Эрдэнэчулуун болон ЭРД нь ЛЭ-ийн Хувьцаа эзэмшигчдийн гэрээг тус тус байгуулсан байна. Хэлцэл хийх, гэрээг байгуулахтай холбоотой бүхий л шийдвэр, тогтоолыг гаргаж, итгэмжлэлийг зохих ёсоор авсан байна. Хувьцаа эзэмшигчдийн бүртгэл ХЭБГ-т зохих ёсоор бүртгэгдсэн байна.
21. ЭРД-ийн бусад Монгол компаниуд болох ЭМ, АР болон ЛЭ нь 2017 онд ямар нэг их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулаагүй байна.

ЭРД болон түүний Монгол компаниудын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл нь хүчин төгөлдөр бөгөөд тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн зэргээр ЭРД болон Монгол компаниудын үйл ажиллагаанд бодитоор нөлөөлж болохуйц нөхцөл үүсээгүй байна.

22. ЭРД нь Монголын компаниудаараа дамжуулан Монгол Улсын нутаг дэвсгэрт эзэмшиж буй ашигт малтмалын тусгай зөвшөөрлүүдээс бусад ямар нэг тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, гэрчилгээ, оюуны өмчийн эрх, барааны тэмдгийг Канад болон өөр бусад оронд эзэмшдэггүй бөгөөд ЭРД-ийн үйл ажиллагаа нь Канадын эрх бүхий байгууллагуудаас ямар нэг зөвшөөрөл шаарддаггүй.
23. ЭМ нь энэхүү Дүгнэлтийг гаргах өдрийн байдлаар Баянхонгор аймгийн Баян-Өндөр, Шинэжинст сумын Хөндий нэртэй газар XV-015569 дугаартай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл, Баянхонгор аймгийн Баян-Өндөр, Шинэжинст сумын Цэнхэр Номин нэртэй газар XV-016956 дугаартай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл, мөн Говь-Алтай аймгийн Цогт сумын Бургаст нэртэй газар XV-017875 дугаартай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг тус тус эзэмшиж байна. Тусгай зөвшөөрөлүүд, тусгай зөвшөөрлийн талбайн газрын эрх болон холбогдох зөвшөөрөл нь хүчин

⁵19-р хэсгийн дүгнэлтийг Канадын Дүгнэлтийн “Дүгнэлт” хэсгийн 12 болон 13-р хэсгээс баталгаажуулж болно.

төгөлдөр байна. Ашигт Малтмал, Газрын Тосны Газар (АМГ)-аас бидний олж авсан тодорхойлолтоор дээрх тусгай зөвшөөрөл нь хүчин төгөлдөр бөгөөд Монгол Улсын Ашигт Малтмалын тухай хууль (*Ашигт Малтмалын хууль*)-ийн дагуу хугацаа нь дуусах, хүчингүй болох ямар нэг нөхцөл бүрдээгүй, тусгай зөвшөөрөл, түүний талбай болон холбогдох зөвшөөрөлтэй холбоотойгоор аливаа төрийн байгууллага, гуравдагч этгээдээс ямар нэг нэхэмжлэл, шаардлага гаргаагүй, захиргааны арга хэмжээ аваагүй, авагдахаар хүлээгдэж буй нөхцөл байдал үүсээгүй болно.

24. АР нь Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Хөвийн Хар нэртэй газар MV-016836 дугаартай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг. Тусгай зөвшөөрөл, тусгай зөвшөөрлийн талбайн газрын эрх болон холбогдох зөвшөөрөл нь хүчин төгөлдөр байна. АМГ-аас бидний олж авсан тодорхойлолтоор дээрх тусгай зөвшөөрөл нь хүчин төгөлдөр бөгөөд Ашигт Малтмалын хуулийн дагуу хугацаа нь дуусах, хүчингүй болох ямар нэг нөхцөл бүрдээгүй, тусгай зөвшөөрөл, түүний талбай болон холбогдох зөвшөөрөлтэй холбоотойгоор аливаа төрийн байгууллага, гуравдагч этгээдээс ямар нэг нэхэмжлэл, шаардлага гаргаагүй, захиргааны арга хэмжээ аваагүй, авагдахаар хүлээгдэж буй нөхцөл байдал үүсээгүй болно.

25. ЛЭ нь Баянхонгор аймгийн Баян-Өндөр, Шинэжинст сумын Улаан нэртэй газар XV-016057 дугаартай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшдэг. Тусгай зөвшөөрөл, тусгай зөвшөөрлийн талбайн газрын эрх болон холбогдох зөвшөөрөл нь хүчин төгөлдөр байна. АМГ-аас бидний олж авсан тодорхойлолтоор дээрх тусгай зөвшөөрөл нь хүчин төгөлдөр бөгөөд Ашигт Малтмалын хуулийн дагуу хугацаа нь дуусах, хүчингүй болох ямар нэг нөхцөл бүрдээгүй, тусгай зөвшөөрөл, түүний талбай болон холбогдох зөвшөөрөлтэй холбоотойгоор аливаа төрийн байгууллага, гуравдагч этгээдээс ямар нэг нэхэмжлэл, шаардлага гаргаагүй, захиргааны арга хэмжээ авагдаагүй, авагдахаар хүлээгдэж буй нөхцөл байдал үүсээгүй болно.

26. АМГ-аас авсан тодорхойлолтоор ЭМ, АР болон ЛЭ-ийн дээрх тусгай зөвшөөрөлтэй холбоотой ямар нэг барьцааны бүртгэл байхгүй байна.

27. Бидний мэдэж байгаа хүрээнд ЭМ, АР болон ЛЭ нь ямар нэг оюуны өмчийн эрх, барааны тэмдэг болон патент эзэмшдэггүй.

ЭРД болон түүний Монгол компаниудын үнэт цаас, үл хөдлөх болон бусад эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр, ямар нэг үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн нөхцөл үүсээгүй байна.

28. ЭМ нь Баянхонгор аймгийн Шинэжинст суманд Баян Хөндийн кэмп байгуулах зорилгоор 20'000 кв газрыг сумын Засаг даргын 2008 оны 11-р сарын 4-ний өдрийн 63 тоот захирамжийн дагуу 2015 оноос эхлэн 15 жилийн хугацаагаар эзэмшдэг. Газар эзэмших эрх нь хүчин төгөлдөр бөгөөд аливаа гуравдагч этгээдийн өмнө хүлээх үүргийн гүйцэтгэлд хамаарч буй нөхцөл илрээгүй байна.

29. АР нь Баянхонгор аймгийн Шинэжинст суманд Зуун Мод кэмп байгуулах зорилгоор 1,8 га газрыг 2011 оны 11-р сарын 17-ны өдрийн 0230777 тоот Гэрчилгээний дагуу 30 жилийн хугацаагаар эзэмшдэг. Газар эзэмших эрх нь хүчин төгөлдөр бөгөөд аливаа гуравдагч этгээдийн өмнө хүлээх үүргийн гүйцэтгэлд хамаарч буй нөхцөл илрээгүй байна.
30. Бидний мэдэж байгаа хүрээнд ЭРД болон ЛЭ нь томоохон үнийн дүн бүхий ямар нэг хөрөнгө өмчилж, эзэмшдэггүй.
31. ЭРД, ЭМ, АР болон ЛЭ-ийн хувьцааны бүртгэл нь холбогдох эрх бүхий байгууллагад зохих ёсоор бүртгэгдсэн. ЭМ, АР болон ЛЭ-ийн ЭРД-ийн эзэмшлийн хэсгийн хувьцаанд ямар нэг барьцааны бүртгэл байхгүй байна.

Давхар бүртгэлтэй холбоотойгоор ЭРД-ээс СЗХ болон МХБ-д гаргаж буй үнэт цаасны өргөдөл, Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан мэдээлэл нь үнэн зөв, хүчин төгөлдөр байна.

32. 2018 оны 2-р сарын 28-ны өдөр ЭРД-ийн Захирлуудын Зөвлөлөөс ЭРД-ийн нийт дөрвөн (4) сая ширхэг хүртэлх Энгийн хувьцааг МХБ-ээр дамжуулан нээлттэй хүрээнд арилжих замаар хөрөнгө татан төвлөрүүлэх, ингэхдээ нэгж Энгийн хувьцааны үнийг Үнэт цаасны танилцуулгын төслийг СЗХ хүргүүлсний дараа, гэхдээ СЗХ-ноос Үнэт цаас гаргах зөвшөөрөл олгохоос өмнө Компанийн зүгээс зөвшөөрсөн өдрөөр дуусгавар болгон ТХБ-д арилжиж буй Энгийн хувьцааны арван өдрийн арилжааны жигнэсэн дундаж ханшаас 10%-ийн хөнгөлөлтийг хассан дүнгээр, ТХБ-ээс авах зөвшөөрлийн хүрээнд баталахыг зөвшөөрсөн байна.
33. ЭРД-ийн Захирлуудын Зөвлөл мөн үнэт цаасыг нээлттэй арилжаалах, МХБ-д бүртгэл хийлгэхтэй холбоотой бүхий л арга хэмжээ авахыг ЭРД-д даалгаад, Монгол Улсын эрх бүхий байгууллагуудтай болон ЭРД-ийн Монгол Улсад оршин суугч хувьцаа эзэмшигчидтэй харилцах, аливаа мэдэгдэл хүлээн авах этгээдээр ЭРД-ийн 100 хувийн эзэмшлийн ЭМ-ыг томилсон байна.
34. Бидэнд ирүүлсэн мэдээлэл, баримт, Канадын хуульчийн мэдэгдэлийн дагуу ЭРД-ийн Захирлуудын Зөвлөлөөс гаргасан дээрх шийдвэр нь ЭРД-ийн үүсгэн байгуулагдаж, үйл ажиллагаа явуулж буй орны хууль тогтоомжийн дагуу хуулийн хүчин төгөлдөр шийдвэр гэж үзэж байна.
35. Канадын хуульчийн баталсанаар ЭРД-ийн Захирлуудын Зөвлөлөөс ЭРД-ийн нийт дөрвөн (4) сая ширхэг хүртэлх Энгийн хувьцааг МХБ-ээр дамжуулан нээлттэй хүрээнд арилжих замаар хөрөнгө татан төвлөрүүлэх шийдвэр гаргасан талаар ТХБ-д албан ёсоор мэдэгдсэн болно.
36. Үнэт цаасны танилцуулга болон Бүртгэлийн өргөдөлд хамаарах бусад баримт бичгийг бэлтгэх ажилд энэхүү Дүгнэлтийг бэлтгэсэн ИЭлСи нөхөрлөл болон Канадын МакИннес Күүпер нөхөрлөлөөс гадна дараах этгээд оролцсон болно:
 - Эрдэнэ Ресорс Девелопмент Корпорэйшн (Канад);
 - Эрдэнэ Монгол ХХК (Монгол);
 - Аниан Ресорсиз ХХК (Монгол);
 - Лидер Эксплорэйшн ХХК (Монгол); мөн
 - БиДиСек ҮЦК ХХК (Монгол).

37. Давхар бүртгэлийн өргөдөл гаргах бэлтгэх ажлын явцад үйлдсэн аливаа баримт бичиг, тэр дундаа Үнэт цаасны танилцуулгад орсон мэдээлэл нь үнэн зөв болохыг батлан дээр дурдсан этгээдээс ирүүлсэн Тодорхойлох захидлыг Дүгнэлтийн 3-р Хавсралтад оруулсан болно.
38. Бидний мэдэж байгаа хүрээнд Үнэт цаасны танилцуулга болон Бүртгэлийн өргөдөлд агуулагдаж байгаа мэдээлэл нь үнэн зөв баримтад үндэслэсэн байна. ЭРД-ийн талаар олон нийтэд ил, тодорхой үйл баримт, түүний үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд тусгагдсан баталгаажуулах боломжгүй тоон үзүүлэлтүүд болон хөрөнгө оруулагчдад санал болгож байгаа арилжааны нөхцөлүүдийн талаар хуульч дүн шинжилгээ хийх боломжгүй тул анхааралдаа авч үнэт цаас гаргагчаас дэлгэрэнгүй тайлбар, мэдээлэл авахыг хуульчийн зүгээс хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдэд санал болгож байна.

Танилцсан баримт бичиг

Дүгнэлтийг бэлтгэх ажлын хүрээнд ИЭлСи нь ЭРД болон түүний Монгол компаниудын ирүүлсэн баримт бичгүүдийн эх хувь, хуулбар болон бидний шаардлагад нийцсэн бусад хэлбэрээр үзэж, танилцсан. Танилцсан баримт бичиг (**Баримт бичиг**)-ийн жагсаалтыг Дүгнэлтийн 2-р Хавсралтад оруулсан болно.

Төсөөлөл

Энэхүү Дүгнэлтийг хуульч нь дараах төсөөлөлд үндэслэн гаргасан болно:

- a) Бидэнд эх хувиар ирүүлсэн аливаа баримт бичиг нь үнэн зөв, бүрэн гүйцэд бөгөөд тухайн эх хувь нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа, түүнд зурсан аливаа гарын үсэг, дарсан тамга тэмдэг, баталгаажуулалт нь жинхэнэ бөгөөд үнэн зөв;
- b) Бидэнд нотариатаар гэрчлүүлэн, зургаар баталгаажуулан, скандаж эсвэл факсаар ирүүлсэн аливаа баримт бичгийн хуулбар болон бусад хэлбэрээр ирүүлсэн баримт бичиг нь эх хувийн үнэн зөв хуулбар бөгөөд тэдгээр эх баримт бичиг нь үнэн зөв, бүрэн гүйцэд, хүчин төгөлдөр үйлчилж байгаа ба түүнд зурсан аливаа гарын үсэг, дарсан тамга тэмдэг, баталгаажуулалт нь жинхэнэ, үнэн зөв;
- c) Хяналт шалгалтад оролцсон аливаа этгээд нь бүрэн гүйцэд, үнэн зөв мэдээлэл өгөх эрх зүйн бүрэн чадамжтай, ирүүлсэн баримт бичгүүд дэх гарын үсэг, баталгааны тэмдэг нь үнэн зөв болохыг энэхүү Дүгнэлтийг гаргахад оролцсон ЭРД болон түүний Монголын компаниудын ажилтнууд баталсан;
- d) Төрийн эрх бүхий байгууллага болон шүүхээс ирүүлсэн аливаа мэдээлэл нь үнэн зөв, хүчин төгөлдөр; мөн
- e) Канадын хуулийн фирмийн ирүүлсэн Канадын дүгнэлт нь харьяалсан улсын хууль тогтоомжийн дагуу хийгдсэн, түүнд агуулагдаж байгаа мэдээлэл нь хүчин төгөлдөр, үнэн зөв.

Тодруулга

- a) Дүгнэлтийн 1.3, 1.4 болон 1.5 дахь хэсгүүдэд дурдсан ХЭБГ-ын тодорхойлолтууд нь тухайн тодорхойлолтыг өгсөн өдрийн байдлаар түүнд дурдсан хуулийн этгээдийг татан буулгах ажиллагаа эхлүүлсэн эсэх мэдээллийг илэрхийлэх боломжтой. Аливаа компани нь татан буулгах тухай шийдвэр гаргаснаас хойш ажлын гурван (3) өдрийн дотор ХЭБГ-т мэдэгдэх үүрэгтэй.
- b) Шүүхээс дампууруулах ажиллагааг эхлүүлэхээс нааш компанийн дампуурлын талаар олон нийтэд мэдэгдэх болон бүртгэл хийлгэх ямар нэг тогтолцоо байхгүй. Дүгнэлтийн 1.3(E), 1.4(E) болон 1.5(E) хэсгүүдэд дурдсан тодорхойлолтууд шүүхээс түүнд дурдсан хуулийн этгээдийг дампууруулах ямар нэг арга хэмжээ авсан эсэх мэдээллийг агуулах боломжтой. Дампууралтай холбоотой аливаа нэхэмжлэлийг хүлээн авснаас хойш хамгийн ихдээ тав хоногийн дотор шүүхээс дампуурлын хэрэг үүсгэх талаар шийдвэр гаргадаг.
- c) ЭРД-ийн зарим мэдээллийг бид олон нийтэд нээлттэй www.sedar.com цахим хуудсаас авсан бөгөөд Канадын дүгнэлтэд дурдсаны дагуу энэхүү цахим хуудас нь Канадын Үнэт Цаасны Удирдлагын Төвөөс албан ёсоор удирдан ажиллуулдаг, нээлттэй компанийн албан ёсны мэдээллийг агуулсан мэдээллийн хэрэгсэл юм. Уг цахим хуудсаас авсан ЭРД-ийн бүхий л мэдээллийг үнэн зөв гэж үзсэн болно.
- d) Дүгнэлтэд дурдсан “бидэнд мэдэгдэж байгаа хүрээнд” гэсэн мэдэгдэл нь тухайн асуудлыг няцаах, үгүйсгэх ямар нэг эсрэг мэдээллийг бид ямар нэг бие даасан мэдээллийн эх сурвалжаас олоогүй, харин олон нийтэд ил болсон, хууль ёсны эх сурвалжаас тухайн асуудлаар мэдээлэл цуглуулсан болохыг илэрхийлнэ.

Дүгнэлтийг ашиглах

Дүгнэлтийг зөвхөн дээр дурдсан зорилгоор ашиглана. Дүгнэлтийг биднээс урьдчилан бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр аливаа зорилгоор хэрэглэх, ишлэх, үндэслэх, хуулбарыг бусад этгээдэд дамжуулж болохгүй. Давхар бүртгэлтэй холбоотойгоор Дүгнэлтийн хуулбарыг та бүхэн (a) өөрийн зөвлөх, хуульчид болон бусад мэргэжлийн шинжээчид, (b) холбогдох улсын хууль тогтоомжийн дагуу хүргүүлэхээр шаардаж буй төрийн эрх бүхий байгууллага, мөн (c) холбогдох улсын хууль тогтоомж, шүүхийн ажиллагааны дагуу гаргаж өгөхөөр зааварчилсан этгээдүүдэд хүргүүлж болно. Үнэт цаасны танилцуулгыг эцэслэснээс хойш холбогдох хууль тогтоомж, нөхцөл байдал, мэдээлэл, гэрээ, хэлцэлд орсон өөрчлөлттэй холбоотойгоор бид энэхүү Дүгнэлтийг засварлах эсвэл дахин гаргах үүрэг хүлээхгүй болно.

Дүгнэлт

НЭГ. КОМПАНИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ

1.1. Компанийн бүтэц

Компанийн бүтцийн хувьд ЭРД нь хэд хэдэн охин компанийн нэгдлээс бүрдэж байна.

Зураг: Дүгнэлт гаргах өдрийн байдлаарх компанийн бүтэц



1.2. ЭРД-ийн бүртгэлийн мэдээлэл (бүртгэлийн дугаар: 377975-1, TSX: ERD)

А. Үүсгэн байгуулагдсан талаарх мэдээлэл⁶

ЭРД нь Канадын Бизнесийн байгууллагын тухай хуулийн дагуу “3779751 Canada Inc.” нэртэйгээр 2000 оны 6-р сарын 27-ны өдөр үүсгэн байгуулагдсан. 2003 оны 2-р сарын 18-ны өдөр компани нь “3779751 Canada Inc.” нэрээ “Эрдэнэ Гоулд Инк.” болгон өөрчилж эцэст нь 2008 оны 5-р сарын 29-ний өдөр одоогийн Эрдэнэ Ресорс Девелопмент Корпорэйшн нэрийг албан ёсоор бүртгүүлсэн байна.

ЭРД-ийн үйл ажиллагааны үндсэн чиглэл нь үнэт, ховор ашигт малтмалын ордыг илрүүлж, уурхайг ашиглах юм. ЭРД нь Монгол Улсад бага зардлаар гарган авах боломжтой, их хэмжээний нөөц бүхий үнэт металын ордыг илрүүлэн, ашиглахад гол анхаарлаа хандуулж байна⁷.

⁶2017 оны 3-р сарын 27-нд гаргасан, 2016 оны 12-р сарын 31-ээр дуусгавар болж буй санхүүгийн жилд хамаарах Жилийн тайлан, 4 болон 5-р хуудас.

⁷2017 оны 3-р сарын 27-нд гаргасан, 2016 оны 12-р сарын 31-ээр дуусгавар болж буй санхүүгийн жилд хамаарах Жилийн тайлан, 8-р хуудас.

Канадын хуульчийн ирүүлсэн Канадын дүгнэлтэд дурдсанаар ЭРД нь Канадын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан, энэхүү Дүгнэлтийг гаргах өдрийн байдлаар өөрийн харьяалсан улсын холбогдох бүртгэлийн байгууллагад бүртгэлтэй байна.

В. Хувьцаа

Энгийн хувьцаа

ЭРД нь хязгааргүй тооны энгийн хувьцааг гаргах эрхтэй⁸. Энэхүү Дүгнэлтийг гаргах өдрийн байдлаар нийт 146'400'586 ширхэг хувьцааг хувьцаа эзэмшигчдэд эзэмшүүлээд байна. Энгийн хувьцаа бүр нь нэг саналын эрхтэй бөгөөд хэрэв Захирлуудын Зөвлөлөөс ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэвэл ногдол ашиг авах, ЭРД татан буугдах нөхцөлд Энгийн хувьцаанд хамаарах үлдсэн хөрөнгөөс авах эрхийг тус тус илэрхийлнэ.

ЭРД нь өөрийн Энгийн хувьцааг ТХБ-ийн Гарааны бизнес санхүүжүүлэх төвд анх 2004 оны 3-р сарын 16-ны өдөр арилжиж эхэлсэн байна.

Хувьцааны опцион

2018 оны 2-р сарын 28-ны өдрийн байдлаар ЭРД нь нэг бүр нь дунджаар 0.39 ам.доллараар хувьцаанд хөрвөх боломжтой 9'316'250 ширхэг опционтой байна. Опцион бүр нь ЭРД-ийн Энгийн хувьцаанд хөрвөх боломжтой.

Ирээдүйд эзэмшүүлэх нэгж хувьцаа

2018 оны 2-р сарын 28-ны байдлаар ЭРД нь нэг бүр нь дунджаар 0.6 ам.доллараар хөрвөх нийт 3'410'186 Ирээдүйд эзэмшүүлэх нэгж хувьцааг тодорхой тооны захирал, ажилтнуудад олгосон байна.

Нөхөн төлбөрийн опцион

2018 оны 2-р сарын 28-ны өдрийн байдлаар ЭРД нь 2019 оны 2-р сарын 22-ны өдөр хүртэл хүчин төгөлдөр, нэг бүр нь 1.20 ам.доллараар хөрвөх нийт 1'075'324 ширхэг Нөхөн төлбөрийн опцион гаргасан байна.

Канадын дүгнэлтээр баталгаажуулсны дагуу, мөн ЭРД-ийн Дүрэмд заасны дагуу ЭРД нь дээрх хувьцаа болон опционыг гаргах эрхтэй бөгөөд шаардлагатай

компанийн шийдвэрийг зохих журмаар гаргасан буюу бусад холбогдох арга хэмжээг авсан болно.

⁸ЭРД-ийн Дүрмийн 24 дүгээр зүйл.

С. ЭРД-ийн Дүрэм

“ЭРД-ийн бизнесийн ерөнхий хэлцэл, асуудлуудыг зохицуулсан Дүрэм” нь 2003 оны 10-р сарын 22-нд батлагдсан бөгөөд сүүлийн нэмэлт, өөрчлөлт нь 2013 оны 4-р сарын 18-д орсон.

ЭРД-ийн Дүрэмд компанийн бизнесийн үйл ажиллагааг удирдан явуулдаг Захирлуудын Зөвлөлийн гишүүдийн тоо, ирц бүрдэлт, тэдгээрт тавигдах шаардлага, захирлуудыг сонгох журам, тэдний бүрэн эрхийн хугацаа, бүрэн эрх дуусгавар болох, Захирлуудын Зөвлөл хуралдах журам, тэдэнд олгох урамшуулал, захирлууд болон эрх бүхий ажилтнуудыг хариуцлагаас чөлөөлөх, Захирлуудын Зөвлөлийн дарга, түүнийг сонгох, хувьцааны талаар, хувьцааны гэрчилгээ, хувьцааг шилжүүлэх, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурал, ирц, санал өгөх эрх болон ногдол ашгийн талаар тусгажээ.

Канадын хуульчийн дүгнэлтэд заасны дагуу ЭРД-ийн Дүрэм болон ҮБББ нь компанийн үйл ажиллагаатай холбоотой Канадын холбогдох хууль тогтоомжуудад нийцсэн бөгөөд тухайн дүгнэлтийг гаргах өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж байна.

D. Татвар

Канадын хуульчийн дүгнэлтээр баталгаажуулсны дагуу ЭРД нь Канадын татварын хууль тогтоомжийг зөрчсөн ямар нэг үйлдэл гаргаагүй, ЭРД-ийн эсрэг татварын хууль тогтоомжийн дагуу үүсгэсэн ямар нэг захиргааны, шүүхийн, арбитрайн татварын нэхэмжлэл байхгүй болно.

E. Татан буулгах ажиллагаа

Канадын хуульчийн өөрийн дүгнэлтэд баталгаажуулсны дагуу ЭРД-тай холбоотой ямар нэг татан буулгах, дампууруулах болон эрх хүлээн авагч томилох арга хэмжээ авагдаагүй, үүнтэй холбоотой ямар нэг эрх бүхий этгээдийн шийдвэр гараагүй, ийм шийдвэр гарах буюу арга хэмжээг авахаар хүлээгдэж буй нөхцөл байдал үүсээгүй болно.

F. Маргаан

Канадын хуульчийн дүгнэлтийн дагуу ЭРД-ийн эсрэг аливаа төрийн эрх бүхий байгууллага, гуравдагч этгээд, хувь хүнээс үүсгэсэн, үүсгэж болзошгүй ямар нэг захиргааны, шүүхийн, арбитрайн хэрэг эсвэл хүлээгдэж буй шүүхийн шийдвэр, албадлагын арга хэмжээний мэдэгдэл байхгүй болно.

1.3. ЭМ-ын бүртгэлийн мэдээлэл (Улсын бүртгэлийн дугаар: 9019005124, регистрийн дугаар: 2718243)

A. Үүсгэн байгуулагдсан талаарх мэдээлэл

ЭМ-ын Дүрэм (сүүлийн нэмэлт, өөрчлөлтийг 2017 оны 1-р сарын 30-ны өдөр ХЭБГ-т бүртгүүлсэн) болон түүний Улсын бүртгэлийн гэрчилгээнээс үзэхэд ЭМ нь 2005 оны 12-р сарын 8-ны өдөр 10'000'000 төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгээр үүсгэн байгуулагдсан байна. ЭМ-ын хувьцаа эзэмшигч 2013 оны 7-р сарын 2-ны өдөр ЭМ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 149'263'000 төгрөг болгон нэмэгдүүлсэн бөгөөд нийт хөрөнгө нь нэг бүр нь 1'000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, нийт 140,263 ширхэг энгийн хувьцаанд хуваагдана.

ЭМ-ын Улсын бүртгэлийн гэрчилгээ болон түүний эзэмшиж буй ашигт малтмалын тусгай зөвшөөрлөөс харахад ЭМ нь гадаад худалдаа эрхлэх (үндсэн үйл ажиллагаанд бүртгэгдсэн) болон ашигт малтмалын хайгуулын үйл ажиллагаа явуулах (туслах үйл ажиллагаанд бүртгэгдсэн) үйл ажиллагааны үндсэн чиглэлтэй байна. ЭМ-ын Дүрэмд хууль тогтоомжоор зөвшөөрсөн бусад үйл ажиллагааны чиглэлийг дурдсан болно. ЭМ нь Монгол Улсад хязгаарлагдмал хариуцлагатай компани⁹ хэлбэрээр, хууль ёсны дагуу үйл ажиллагаа явуулж байна.

ХЭБГ-аас бидэнд ирүүлсэн 2018 оны 1-р сарын 29-ний өдрийн 00282422 тоот Тодорхойлолтоор ЭМ нь тус газарт гадаадын хөрөнгө оруулалттай компани хэлбэрээр бүртгэлтэй байна.

В. Хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц

Энэхүү Дүгнэлтийг гаргах өдрийн байдлаар ЭМ-ын ХЭБГ-т бүртгэгдсэн хувь нийлүүлсэн хөрөнгө нь 149'263'000 (нэг зуун дөчин есөн сая хоёр зуун жаран гурван мянга) төгрөг бөгөөд нэгж хувьцааны нэрлэсэн үнэ нь 1'000 (нэг мянга) төгрөг байна. Хувьцаа эзэмшлийн төлбөр бүрэн төлөгдсөн бөгөөд ЭМ-ын цорын ганц хувьцаа эзэмшигч болох ЭРД-ийн нэр дээр бүртгэгдсэн байна.

ХЭБГ-ын 00282422 тоот Тодорхойлолтоос үзэхэд хувь нийлүүлсэн хөрөнгөд орсон аливаа өөрчлөлт нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу хийгдэж, холбогдох бүртгэлийг хийлгэсэн байна.

2017 оны 1-р сарын 30-ны өдрийг хүртэл ЭМ-ын цорын ганц хувьцаа эзэмшигч нь Эрдэнэ Интернэйшнл Эксплорэйшн Инк. байсан бөгөөд тус өдрөөс ЭРД нь ЭМ-ын 100 хувийн хувьцаа эзэмшигч болсон байна.

ХЭБГ-ын 00282422 тоот Тодорхойлолтоос үзэхэд хувьцаа эзэмшигч өөрчлөх аливаа хэлцэл нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу хийгдсэн, шаардлагатай бүртгэлийг хийлгэсэн байна.

ЭМ-ын Улсын бүртгэлийн гэрчилгээнээс харахад түүний үйл ажиллагаа эрхлэх хугацаа нь 2020 оны 2-р сарын 27-ны өдөр дуусгавар болохоор байна. Улсын бүртгэлийн гэрчилгээнд тусгасан үйл ажиллагаа эрхлэх хугацаа нь компанийн гаргасан хүсэлтийн дагуу хялбар сунгагддаг бөгөөд энэ нь ЭМ-ын эрх зүйн байдалд ямар нэг нөлөө үзүүлэхгүй.

⁹“Хязгаарлагдмал хариуцлагатай компани гэж хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, түүнийг захиран зарцуулах эрх нь хууль болон компанийн дүрмээр хязгаарлагддаг компанийг хэлнэ”, Компанийн тухай хууль, 3 дугаар зүйлийн 3.5

ЭМ-ын ирүүлсэн мэдээлэл, Баримт бичиг болон бидний мэдэж байгаа хүрээнд ЭМ нь үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулдаг бөгөөд тэдгээр хууль тогтоомжоор хүлээсэн аливаа үүргээ биелүүлсээр ирсэн байна.

С. ЭМ-ын Дүрмийн хүчин төгөлдөр байдал

Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй ЭМ-ын Дүрмийг хувьцаа эзэмшигч 2016 оны 12-р сарын 15-ны өдөр баталсан. ЭМ-ын Дүрэм нь Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2¹⁰ дахь хэсэгт дурдсан шаардлагын дагуу дараах зүйлсийг тусгасан байна:

- ЭМ-ын оноосон нэр, түүний товчлол (1 дүгээр зүйл);
- Зарласан болон гаргасан хувьцааны мэдээлэл, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ (4-өөс 7 дугаар зүйл);
- ЭМ-ын үйл ажиллагааны чиглэл (3 дугаар зүйл);
- Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрх (13 дугаар зүйл);
- Төлөөлөн удирдах зөвлөлийг томилох, түүний бүрэн эрх (16-аас 20 дугаар зүйл); мөн
- ЭМ-ын удирдлагын тогтолцоо (24 дүгээр зүйл).

Уг Дүгнэлтийг гаргах өдрийн байдлаар ЭМ-ын Дүрэм нь Компанийн хуулийн шаардлагад нийцсэн, хүчин төгөлдөр баримт бичиг байна.

D. Татвар

2018 оны 1-р сарын 24-ний өдөр Татварын Ерөнхий Газрын татварын цахим бүртгэлийн системээс авсан 1801240534115 тоот Тодорхойлолт болон Захиргааны Хэргийн Анхан Шатны Шүүхээс¹¹ 2018 оны 2-р сарын 2-ны өдөр бидэнд ирүүлсэн 2/290 тоот Тодорхойлолт зэргээс үзэхэд ЭМ нь Монгол Улсын татварын хууль тогтоомж зөрчөөгүй, ЭМ-ын эсрэг ямар нэг татварын нэхэмжлэл, маргаан үүсээгүй болно.

ЭМ нь хууль тогтоомжийн дагуу шаардсан аливаа орлогын, нэмэгдсэн өртгийн болон бусад хөрөнгийн татварын тайланг холбогдох төрийн байгууллагад зохих журмаар хүргүүлсэн. Тэдгээр тайлан мэдээг зохих журмын дагуу боловсруулсан бөгөөд татвар төлөлттэй холбоотой ямар нэг маргаан байхгүй болно.

2018 оны 1-р сарын 29-ний өдөр Сүхбаатар Дүүргийн Нийгмийн Даатгалын Хэлтсээс бидэнд ирүүлсэн 113 тоот Тодорхойлолтоос үзэхэд ЭМ нь нийгмийн даатгалын шимтгэл төлөгч байгууллагаар бүртгэгдсэн, дээрх өдрийн байдлаар нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн өргүй байна.

¹⁰ Компанийн дүрэмд дараах зүйлсийг заавал тусгана: (i) компанийн бүрэн болон товчилсон оноосон нэр, түүний хэлбэрийг тодорхойлох товчилсон ялгах тэмдэглэгээ, (ii) компанийн зарласан болон гаргасан хувьцааны тоо, тэдгээрийн төрөл, нэрлэсэн үнэ, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, (iii) компанийн дүрмээр давуу эрхийн хувьцааг зарласан нөхцөлд давуу эрхийн хувьцааны зарласан тоо, түүний эзэмшигчийн эрх, (iv) хэрэв төлөөлөн удирдах зөвлөлтэй байхаар шийдвэрлэсэн бол төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоо, (v) хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөлийн хуулиар тодорхойлсоноос бусад бүрэн эрх, мөн (vi) компанийн үйл ажиллагааны чиглэл.

¹¹ Монгол Улсын Захиргааны Ерөнхий Хуулийн дагуу татварын хэрэг маргааны шүүхийн харьяалал нь Захиргааны шүүхэд хамаарна.

Е. Татан буулгах ажиллагаа

Бидний мэдэж байгаа хүрээнд, 2018 оны 1-р сарын 29-ний өдөр Шүүхийн Төрөлжсөн Архиваас ирүүлсэн 836 тоот Тодорхойлолтоос үзэхэд ЭМ-тэй холбоотой ямар нэг татан буулгах, дампууруулах болон эрх хүлээн авагч томилох арга хэмжээ авагдаагүй, үүнтэй холбоотой ямар нэг эрх бүхий этгээдийн шийдвэр гараагүй, ийм шийдвэр гарах буюу арга хэмжээг авахаар хүлээгдэж буй нөхцөл байдал үүсээгүй болно.

Ғ. Маргаан

Бидний мэдэж байгаа хүрээнд ЭМ-ын эсрэг аливаа төрийн эрх бүхий байгууллага, гуравдагч этгээд, хувь хүнээс үүсгэсэн, үүсгэж болзошгүй ямар нэг захиргааны, шүүхийн, арбитрын хэрэг эсвэл хүлээгдэж буй шүүхийн шийдвэр, албадлагын арга хэмжээний мэдэгдэл байхгүй болно. Энэ нь Шүүхийн Төрөлжсөн Архиваас ирүүлсэн 836 тоот Тодорхойлолт, Захиргааны Хэргийн Анхан Шатны Шүүхээс 2018 оны 2-р сарын 2-ны өдөр бидэнд ирүүлсэн 2/290 тоот Тодорхойлолт, Монголын Олон Улсын болон Үндэсний Арбитраас 2018 оны 1-р сарын 29-ний өдөр ирүүлсэн 4/82 тоот Тодорхойлолт болон Нийслэлийн Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Албанаас 2018 оны 1-р сарын 26-ны өдөр ирүүлсэн 0048833 тоот Тодорхойлолтоор тус тус нотлогдож байна.

1.4. АР-ын бүртгэлийн мэдээлэл (Улсын бүртгэлийн дугаар: 9019005122, регистрийн дугаар: 2874229)

А. Үүсгэн байгуулсан тухай мэдээлэл

АР-ын Дүрэм (сүүлийн нэмэлт, өөрчлөлтийг 2017 оны 5-р сарын 7-ны өдөр ХЭБГ-т бүртгүүлсэн) болон түүний Улсын бүртгэлийн гэрчилгээнээс харахад АР нь 2005 оны 12-р сарын 7-ны өдөр 648'204'000 төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгээр үүсгэн байгуулагдсан бөгөөд хувь нийлүүлсэн хөрөнгө нь нэг бүр нь 12'000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийт 54'017 ширхэг энгийн хувьцаанд хуваагдана. АР нь Дүрэмдээ нийт 100'000 хувьцаа гаргахаар зарласан.

АР-ын Улсын бүртгэлийн гэрчилгээ болон түүний эзэмшиж буй ашигт малтмалын тусгай зөвшөөрлөөс үзэхэд АР нь гадаад худалдаа эрхлэх (үндсэн үйл ажиллагаанд бүртгэгдсэн) болон ашигт малтмалын хайгуулын үйл ажиллагаа явуулах (туслах үйл ажиллагаанд бүртгэгдсэн) үйл ажиллагааны үндсэн чиглэлтэй байна. АР-ын Дүрэмд хууль тогтоомжоор зөвшөөрсөн бусад үйл ажиллагааны чиглэлийг дурдсан болно. АР нь Монгол Улсын хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр, хууль ёсны дагуу үйл ажиллагаа явуулж байна.

ХЭБГ-аас бидэнд ирүүлсэн 2018 оны 1-р сарын 29-ний өдрийн 00282423 тоот Тодорхойлолтоор АР нь тус газарт гадаадын хөрөнгө оруулалттай компани хэлбэрээр бүртгэлтэй байна.

В. Хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц

Энэхүү Дүгнэлтийг гаргах өдрийн байдлаар АР-ын ХЭБГ-т бүртгэгдсэн хувь нийлүүлсэн хөрөнгө нь 648'204'000 (зургаан зуун дөчин найман сая хоёр зуун дөрвөн мянга) төгрөг бөгөөд нэгж хувьцааны нэрлэсэн үнэ нь 12'000 (арван хоёр мянга) төгрөг байна. Хувьцаа эзэмшлийн төлбөр бүрэн төлөгдсөн бөгөөд АР-ын цорын ганц хувьцаа эзэмшигч болох ЭРД-ийн нэр дээр бүртгэгдсэн байна.

АР-ын 100 хувийн хувьцаа нь анх Бермудын компани болох Тамерлан Интернэйшнл Лимитэдийн эзэмшилд байсан бөгөөд 2013 оны 11-р сарын 15-ны өдрөөс хувьцаа бүхэлдээ Эрдэнэ Интернэйшнл Эксплорэйшн Инк.-д шилжин очсон байна. 2017 оны 1-р сарын 30-ны өдөр АР-ын 100 хувийн хувьцаа эзэмшигчээр ЭРД бүртгэгдсэн байна.

ХЭБГ-ын 00282423 тоот Тодорхойлолтоос үзэхэд хувьцаа эзэмшигч өөрчлөх аливаа хэлцэл нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу хийгдсэн, шаардлагатай бүртгэлийг хийлгэсэн байна.

АР-ын Улсын бүртгэлийн гэрчилгээнээс харахад түүний үйл ажиллагаа эрхлэх хугацаа нь 2020 оны 2-р сарын 25-ны өдөр дуусгавар болохоор байна. Улсын бүртгэлийн гэрчилгээнд тусгасан үйл ажиллагаа эрхлэх хугацаа нь компанийн гаргасан хүсэлтийн дагуу хялбар сунгагддаг бөгөөд энэ нь АР-ын эрх зүйн байдалд ямар нэг нөлөө үзүүлэхгүй.

АР-ын ирүүлсэн мэдээлэл, Баримт бичиг болон бидний мэдэж байгаа хүрээнд АР нь үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулдаг бөгөөд тэдгээр хууль тогтоомжоор хүлээсэн аливаа үүргээ биелүүлсээр ирсэн байна.

С. АР-ын Дүрмийн хүчин төгөлдөр байдал

Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй АР-ын Дүрмийг хувьцаа эзэмшигч 2016 оны 12-р сарын 15-ны өдөр баталсан. ЭМ-ын Дүрэм нь Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэгт дурдсан шаардлагын дагуу дараах зүйлсийг тусгасан байна:

- АР-ын оноосон нэр, түүний товчлол (1 дугаар зүйл);
- Зарласан болон гаргасан хувьцааны мэдээлэл, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ (4-өөс 7 дугаар зүйл);
- АР-ын үйл ажиллагааны чиглэл (3 дугаар зүйл);
- Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрх (13 дугаар зүйл);
- Төлөөлөн удирдах зөвлөлийг томилох, түүний бүрэн эрх (16-аас 20 дугаар зүйл); мөн
- АР-ын удирдлагын тогтолцоо (24 дүгээр зүйл).

Уг Дүгнэлтийг гаргах өдрийн байдлаар АР-ын Дүрэм нь Компанийн хуулийн шаардлагад нийцсэн, хүчин төгөлдөр баримт бичиг байна.

D. Татвар

2018 оны 1-р сарын 24-ний өдөр Татварын Ерөнхий Газрын татварын цахим бүртгэлийн системээс авсан 1801240534190 тоот Тодорхойлолт болон Захиргааны Хэргийн Анхан Шатны Шүүхээс 2018 оны 2-р сарын 2-ны өдөр бидэнд ирүүлсэн 2/292 тоот Тодорхойлолт зэргээс үзэхэд АР нь Монгол Улсын татварын хууль тогтоомж зөрчөөгүй, АР-ын эсрэг ямар нэг татварын нэхэмжлэл, маргаан үүсээгүй болно.

ЭМ нь хууль тогтоомжийн дагуу шаардсан аливаа орлогын, нэмэгдсэн өртгийн болон бусад хөрөнгийн татварын тайланг холбогдох төрийн байгууллагад зохих журмаар хүргүүлсэн. Тэдгээр тайлан мэдээг зохих журмын дагуу боловсруулсан бөгөөд татвар төлөлттэй холбоотой ямар нэг маргаан байхгүй болно.

2018 оны 1-р сарын 29-ний өдөр Чингэлтэй Дүүргийн Нийгмийн Даатгалын Хэлтсээс бидэнд ирүүлсэн 191 тоот Тодорхойлолтоос үзэхэд АР нь нийгмийн даатгалын шимтгэл төлөгч байгууллагаар бүртгэгдсэн, дээрх өдрийн байдлаар нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн өргүй байна.

E. Татан буулгах ажиллагаа

Бидний мэдэж байгаа хүрээнд болон 2018 оны 1-р сарын 29-ний өдөр Шүүхийн Төрөлжсөн Архиваас ирүүлсэн 837 тоот Тодорхойлолтоос үзэхэд АР-тэй холбоотой ямар нэг татан буулгах, дампууруулах болон эрх хүлээн авагч томилох арга хэмжээ авагдаагүй, үүнтэй холбоотой ямар нэг эрх бүхий этгээдийн шийдвэр гараагүй, ийм шийдвэр гарах буюу арга хэмжээг авахаар хүлээгдэж буй нөхцөл байдал үүсээгүй болно.

F. Маргаан

Бидний мэдэж байгаа хүрээнд АР-ын эсрэг аливаа төрийн эрх бүхий байгууллага, гуравдагч этгээд, хувь хүнээс үүсгэсэн, үүсгэж болзошгүй ямар нэг захиргааны, шүүхийн, арбитрын хэрэг эсвэл хүлээгдэж буй шүүхийн шийдвэр, албадлагын арга хэмжээний мэдэгдэл байхгүй болно. Энэ нь Шүүхийн Төрөлжсөн Архиваас ирүүлсэн 837 тоот Тодорхойлолт, Захиргааны Хэргийн Анхан Шатны Шүүхээс 2018 оны 2-р сарын 2-ны өдөр бидэнд ирүүлсэн 2/292 тоот Тодорхойлолт, Монголын Олон Улсын болон Үндэсний Арбитраас 2018 оны 1-р сарын 29-ний өдөр ирүүлсэн 4/80 тоот Тодорхойлолт болон Нийслэлийн Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Албанаас 2018 оны 1-р сарын 26-ны өдөр ирүүлсэн 0048835 тоот Тодорхойлолтоор тус тус нотлогдож байна.

1.5. ЛЭ-ийн бүртгэлийн мэдээлэл (Улсын бүртгэлийн дугаар: 9011672102, регистрийн дугаар: 6183077)

A. Үүсгэн байгуулсан тухай мэдээлэл

ЛЭ-ийн Дүрэм (сүүлийн нэмэлт, өөрчлөлтийг 2017 оны 8-р сарын 23-ны өдөр ХЭБГ-т бүртгүүлсэн) болон түүний Улсын бүртгэлийн гэрчилгээнээс харахад ЛЭ нь 2017 оны 5-р сарын 8-ны өдөр 20'000 төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгээр үүсгэн

байгуулагдсан бөгөөд хувь нийлүүлсэн хөрөнгө нь нэг бүр нь 1'000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийт 20 ширхэг энгийн хувьцаанд хуваагдаж байсан.

2017 оны 8-р сарын 23-нд ЛЭ-ийн 51 хувийн хувьцааг ЭМ шилжүүлэн авч, улмаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 100'000 төгрөг болгон нэмэгдүүлсэн. Дүгнэлт гаргах өдрийн байдлаар дээрх хувь нийлүүлсэн хөрөнгө нь нэг бүр нь 1'000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 100 ширхэг хувьцаанд хуваагдаж байна.

ЛЭ-ийн Улсын бүртгэлийн гэрчилгээ болон түүний эзэмшиж буй ашигт малтмалын тусгай зөвшөөрлөөс харахад ЛЭ нь гадаад худалдаа эрхлэх (үндсэн үйл ажиллагаанд бүртгэгдсэн) болон ашигт малтмалын хайгуул хийх болон уул уурхайн зөвлөх үйлчилгээ үзүүлэх (туслах үйл ажиллагаанд бүртгэгдсэн) үйл ажиллагааны үндсэн чиглэлтэй байна. ЛЭ-ийн Дүрэмд хууль тогтоомжоор зөвшөөрсөн бусад үйл ажиллагааны чиглэлийг дурдсан болно. ЛЭ нь Монгол Улсын хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр, хууль ёсны дагуу үйл ажиллагаа явуулж байна.

ХЭБГ-аас бидэнд ирүүлсэн 2018 оны 1-р сарын 29-ний өдрийн 00282424 тоот Тодорхойлолтоор ЛЭ нь тус газарт дотоодын хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр бүртгэлтэй байна.

В. Хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц

Энэхүү Дүгнэлтийг гаргах өдрийн байдлаар ЛЭ-ийн ХЭБГ-т бүртгэгдсэн хувь нийлүүлсэн хөрөнгө нь 100'000 (нэг зургаан зуун мянга) төгрөг бөгөөд нэгж хувьцааны нэрлэсэн үнэ нь 1'000 (нэг мянга) төгрөг байна. ЛЭ-ийн Дүрэмд заасан хувьцаа эзэмшигчид нь хувьцаа эзэмшлийн хөрөнгө оруулалтыг бүрэн оруулсан байна.

2017 оны 8-р сарын 18-ны өдөр ЭМ нь ЛЭ-ийн 51 хувийн хувьцааг шилжүүлэн авч, үлдсэн 49 хувийг эзэмшигч Монгол Улсын иргэн Загдрагчаагийн Эрдэнэчулуунтай Хувьцаа эзэмшигчдийн гэрээг байгуулсан. ЛЭ-ийн одоогийн 49 хувийн хувьцаа эзэмшигч З.Эрдэнэчулуун нь өмнө нь ЛЭ-ийн 50 хувийн хувьцааг эзэмшиж, нөгөө 50 хувийн хувьцааг Загдрагчаагийн Эрдэнэчуяг эзэмшиж байжээ.

2017 оны 8-р сарын 18-ны өдрийн Хувьцаа худалдах, худалдан авах гэрээгээр З.Эрдэнэчуяг өөрийн эзэмшлийн ЛЭ-ийн 50 хувийн хувьцааг ЭМ-д шилжүүлж, З.Эрдэнэчулуун өөрийн хувьцаанаас 1 хувийг ЭМ-д шилжүүлэн улмаар ЭМ нь ЛЭ-ийн 51 хувийн хувьцаа эзэмшигч болсон.

ХЭБГ-ын 00282424 тоот Тодорхойлолтоос үзэхэд хувьцаа эзэмшигч өөрчлөх аливаа хэлцэл нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу хийгдсэн, шаардлагатай бүртгэлийг хийлгэсэн байна.

ЛЭ-ийн Улсын Бүртгэлийн Гэрчилгээ болон ЛЭ-ийн Дүрмээс харахад ЛЭ нь үйл ажиллагаагаа хугацаагүйгээр явуулахаар заасан байгаа тул ямар нэг сунгалтыг бүртгэлийн байгууллагад хийлгэх шаардлагагүй юм.

ЛЭ-ийн ирүүлсэн мэдээлэл, Баримт бичиг болон бидний мэдэж байгаа хүрээнд ЛЭ нь үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулдаг бөгөөд тэдгээр хууль тогтоомжоор хүлээсэн аливаа үүргээ биелүүлсээр ирсэн байна.

С. ЛЭ-ийн Дүрмийн хүчин төгөлдөр байдал

Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй ЛЭ-ийн Дүрмийг хувьцаа эзэмшигч 2017 оны 8-р сарын 18-ны өдөр баталсан. ЛЭ-ийн Дүрэм нь Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэгт дурдсан шаардлагын дагуу дараах зүйлсийг тусгасан байна:

- ЛЭ-ийн оноосон нэр, түүний товчлол (1 дүгээр зүйл);
- Зарласан болон гаргасан хувьцааны мэдээлэл, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ (4-өөс 7 дугаар зүйл);
- ЛЭ-ийн үйл ажиллагааны чиглэл (3 дугаар зүйл);
- Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрх (13 дугаар зүйл);
- Төлөөлөн удирдах зөвлөлийг томилох, түүний бүрэн эрх (16-аас 20 дугаар зүйл); мөн
- ЛЭ-ийн удирдлагын тогтолцоо (24 дүгээр зүйл).

Уг Дүгнэлтийг гаргах өдрийн байдлаар ЛЭ-ийн Дүрэм нь Компанийн хуулийн шаардлагад нийцсэн, хүчин төгөлдөр баримт бичиг байна.

D. Татвар

2018 оны 1-р сарын 24-ний өдөр Татварын Ерөнхий Газрын татварын цахим бүртгэлийн системээс авсан 1801240534193 тоот Тодорхойлолт болон Захиргааны Хэргийн Анхан Шатны Шүүхээс 2018 оны 2-р сарын 2-ны өдөр бидэнд ирүүлсэн 2/291 тоот Тодорхойлолт зэргээс үзэхэд ЛЭ нь Монгол Улсын татварын хууль тогтоомж зөрчөөгүй, ЛЭ-ийн эсрэг ямар нэг татварын нэхэмжлэл, маргаан үүсээгүй болно.

ЛЭ нь хууль тогтоомжийн дагуу шаардсан аливаа орлогын, нэмэгдсэн өртгийн болон бусад хөрөнгийн татварын тайланг холбогдох төрийн байгууллагад зохих журмаар хүргүүлсэн. Тэдгээр тайлан мэдээг зохих журмын дагуу боловсруулсан бөгөөд татвар төлөлттэй холбоотой ямар нэг маргаан байхгүй болно.

2018 оны 2-р сарын 2-ны өдөр Хан-Уул Дүүргийн Нийгмийн Даатгалын Хэлтсээс бидэнд ирүүлсэн 1/154 тоот Тодорхойлолтоос үзэхэд ЛЭ нь нийгмийн даатгалын шимтгэл төлөгч байгууллагаар бүртгэгдсэн, дээрх өдрийн байдлаар нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн өргүй байна.

E. Татан буулгах ажиллагаа

Бидний мэдэж байгаа хүрээнд болон 2018 оны 1-р сарын 29-ний өдөр Шүүхийн Төрөлжсөн Архиваас ирүүлсэн 838 тоот Тодорхойлолтоос үзэхэд ЛЭ-тэй холбоотой ямар нэг татан буулгах, дампууруулах болон эрх хүлээн авагч томилох арга хэмжээ авагдаагүй, үүнтэй холбоотой ямар нэг эрх бүхий этгээдийн шийдвэр гараагүй, ийм

шийдвэр гарах буюу арга хэмжээг авахаар хүлээгдэж буй нөхцөл байдал үүсээгүй болно.

Ф. Маргаан

Бидний мэдэж байгаа хүрээнд ЛЭ-ийн эсрэг аливаа төрийн эрх бүхий байгууллага, гуравдагч этгээд, хувь хүнээс үүсгэсэн, үүсгэж болзошгүй ямар нэг захиргааны, шүүхийн, арбитрын хэрэг эсвэл хүлээгдэж буй шүүхийн шийдвэр, албадлагын арга хэмжээний мэдэгдэл байхгүй болно. Энэ нь Шүүхийн Төрөлжсөн Архиваас ирүүлсэн 838 тоот Тодорхойлолт, Захиргааны Хэргийн Анхан Шатны Шүүхээс 2018 оны 2-р сарын 2-ны өдөр бидэнд ирүүлсэн 2/291 тоот Тодорхойлолт, Монголын Олон Улсын болон Үндэсний Арбитраас 2018 оны 1-р сарын 29-ний өдөр ирүүлсэн 4/81 тоот Тодорхойлолт болон Нийслэлийн Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Албанаас 2018 оны 1-р сарын 26-ны өдөр ирүүлсэн 0048834 тоот Тодорхойлолтоор тус тус нотлогдож байна.

ХОЁР. БҮРЭН ЭРХ, ИТГЭМЖЛЭЛ

2.1. ЭРД-ийн удирдлагын багийн бүрэн эрх

А. Захирлуудын Зөвлөлийн бүрэн эрх

Захирлууд нь Корпорац (ЭРД)-ийн бизнес болон үйл ажиллагааг удирдан зохион байгуулна¹². ЭРД-ийн удирдлагын баг нь найман (8) захирал болон хоёр (2) гүйцэтгэх удирдлагын ажилтнаас бүрдэнэ. Захирал тус бүрийн бүрэн эрхийн хугацаа нь дараа жилийн Хувьцаа эзэмшигчдийн хурал хүртэл эсвэл өөр этгээдийг томилох хүртэл хугацаагаар үргэлжилнэ¹³. ЭРД-ийн Дүрмийн 10 болон 56(b) заалтуудад заасны дагуу Захирлуудын Зөвлөлийн гишүүдийг хувьцаа эзэмшигчдээс томилно.

ЭРД-ийн одоогийн Захирлуудын Зөвлөлийн гишүүд нь 2017 оны 6-р сарын 14-ний өдөр хуралдсан Хувьцаа эзэмшигчдийн жилийн, ээлжит бус хурлаас томилогдсон. Бидэнд ирүүлсэн Канадын Дүгнэлтэд баталгаажуулсны дагуу дээр дурдсан ЭРД-ийн 2017 оны Хувьцаа эзэмшигчдийн хурал нь ЭРД-ийн Дүрэм болон Канадын холбогдох хууль тогтоомжийн дагуу зарлагдаж, хуралдсан бөгөөд ЭРД-ийн Захирлуудын Зөвлөлийг томилох хувьцаа эзэмшигчдийн тогтоол нь хууль ёсны бөгөөд хүчин төгөлдөр байна.

Захирал нь арван найм (18) болон түүнээс дээш настай, ямар нэг дампуурлын хэрэгт холбогдоогүй, сэтгэцийн өөрчлөлтгүй, тийнхүү Канадын болон бусад орны шүүхээс тогтоогдоогүй этгээд байна. Хэрэв дээрх нөхцөлүүд аливаа захиралд тогтоогдсон тохиолдолд тухайн этгээдийн бүрэн эрх дуусгавар болсонд тооцно¹⁴.

Дараах хүснэгтэд ЭРД-ийн захирал болон гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлдэг ажилтнуудын нэр болон холбогдох мэдээллийг тусгав.

¹²ЭРД-ийн Дүрмийн 6 дугаар зүйл

¹³ЭРД-ийн Дүрмийн 10 дугаар зүйл

¹⁴ЭРД-ийн Дүрмийн 8 дугаар зүйл

Хүснэгт: ЭРД-ийн захирлуудын мэдээлэл

Нэр, оршин суугаа газар	Албан тушаал	Захирал / ажилтнаар ажиллаж буй (оноос хойш)
Петер С. Акерли, Канад, Нова Скотиа	Ерөнхийлөгч, Гүйцэтгэх захирал, ЭМ болон АР-ын Гүйцэтгэх захирал	2003 оны 2-р сарын 25
Др. Анна Г. Биолик, Канад, Бритиш Колумб	Захирал	2016 оны 6-р сарын 14
Виллиам Б. Бартон, Канад, Нова Скотиа	Захирал	2004 оны 8-р сарын 25
Жон П. Бюрн, Канад, Онтарио	Захирал	2004 оны 8-р сарын 25
Ж.К. (Крис) Кован, Канад, Онтарио	Захирлуудын Зөвлөлийн дарга	2003 оны 2-р сарын 25
Т. Лэйтон Крофт, АНУ, Өмнөд Каролина	Захирал	2015 оны 7-р сарын 2
Кеннет В. МакДоналд, Канад, Нова Скотиа	Дэд ерөнхийлөгч, Санхүү эрхэлсэн захирал	2003 оны 2-р сарын 25
Дэвид В. Мошер, Канад, Нова Скотиа	Захирал	2016 оны 6-р сарын 14
Филип Л. Вэбстер, Канад, Кьюбик	Захирал	2006 оны 6-р сарын 14

В. Удирдлагын багийн танилцуулга

Петер С. Акерли

Ноён Акерли нь ашигт малтмалын хайгуул, компанид санхүүжилт босгох томоохон төслүүдийг хэрэгжүүлэх боло н олон улсын зах зээлд хувьцаа гаргасан нээлттэй хувьцаат компаниудад удирдах албан тушаал хашиж байсан 25 жилийн туршлагатай. Тэрээр ЭРД-ийн үүсгэн байгуулагч, захирлуудын нэг бөгөөд 2013 оны 3 сараас эхлэн тус компанийн Ерөнхийлөгч, гүйцэтгэх багийн тэргүүнээр ажиллаж байна. Ноён Акерли нь геологич мэргэжилтэй бөгөөд Монгол Улсын молибдэни, зэсийн томоохон нөөцийг тогтоох, Алтан Нар төслийн алтны нөөцийг тодорхойлох, илрүүлэх мөн Баян Хөндийн алтны төслийн хайгуулын ажил зэрэгт техникийн багийг ахлан ажиллаж байсан. 2004 онд компаниа хувьцаат компани болгосон цагаас хойш, хорь гаруй компанийн нэгдэх, нийлэх, хувьцаат компани болон өөрчлөн зохион байгуулах, түүнчлэн санхүүжилт, удирдлагын ажлыг гүйцэтгэж байсан арвин туршлагатай. Ноён Акерли нь Темекс Ресорсис Корпорейшнийг Лаке Шоре Голд Корпорейшнд худалдах ажлыг зохион байгуулах зөвлөл болон тусгай хороонд зөвлөгөө өгч ажиллаж байсан бөгөөд Мориен Ресорсис Корпорейшний даргаар ажиллаж байхдаа Донкин Коал, Блэк Пойнт Агрегате төслийн борлуулалтыг хувьцааны эрхийн шимтгэл болгон хөрвүүлэх ажиллагаанд оролцож

байсан.Түүнчлэн тэрээр Нова Скотиад болсон Катапүлт манлайллын хөтөлбөрт компани гол ивээн тэтгэгчээр оролцох ажилд манлайлан ажилласан. Ноён Акерли Халифакс дахь Сейнт Меригийн их сургуулийг геологийн чиглэлээр шинжлэх ухааны баклавын (1988) зэрэгтэйгээр төгссөн ба “Компанийн захирлуудын аудитын хорооны үр ашиг институт”-ыг 2012 оны 12 сард дүүргэсэн.

Др. Анна Г.Биолик

Др. Биолик нь төрийн болон хувийн хэвшилд 30 гаруй жил ажилласан туршлагатай бөгөөд Канадын Төв Азийн бизнес, дипломат харилцааны асуудлаарх нөлөө бүхий экспертүүдийн нэг юм.2010-2012 оны хугацаанд, Др. Биолик нь Канадын Номхон далайн бүсийн улсуудын олон улсын худалдаа, гадаад харилцааны албаны захирлаар ажиллаж байсан.Др. Биолик нь төрийн албанд ажиллаж байгаад 2012 онд тэтгэвэртээ гарсан.Тэрээр 2014 он хүртэл бизнесийн стратеги, худалдааны чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлдэг Аллам Адвайзори Группын Гүйцэтгэх захирал, Дэд захирал болон бие даасан хараат бус зөвлөхөөр ажиллаж байсан.Мөн 2008 онд Канад улсаас Монгол Улсад суугаа анхны бүрэн эрхт төлөөлөгчөөр ажиллаж Канадын Элчин сайдын яамыг Монгол Улсад анхлан нээх ажлыг удирдан зохион байгуулсан. Түүнчлэн Канадаас Казахстан, Кыргызстан, Тажикстан улсуудад суух элчин сайд, Оросын Холбооны Улсын Санкт Петербург хотод байрлах өргөмжит консул зэрэг ажил, албан тушаалыг хашиж байсан бөгөөд Канадын Захирагчийн албаны олон улсын харилцаа болон улс төрийн хэргийн газарт ахлах зөвлөх, Олон улсын бизнесийн боломжийн газрын захирал, Канадын Хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааны төвийн ахлах менежер, Канад Постын Европыг хариуцсан маркетингийн менежер зэрэг албыг хашиж байсан. Др. Биолик нь олон улсын худалдааны салбарт ажиллаж байсан өргөн туршлагатай бөгөөд өсөн нэмэгдэж буй зах зээлд Канадын компаниудтай ойр ажиллаж байсан.Др. Биолик нь одоогийн байдлаар Викториа дахь Роял Рөүдс их сургуульд Хөтөлбөрийн болон судалгааны зөвлөлийн гишүүнээр, Хойд Америк-Монголын бизнесийн зөвлөлийн Канадын талын Удирдах зөвлөлийн гишүүнээр ажиллаж байна.Тэрээр Канадын Төрийн удирдлагын институтийн гишүүн.Монреалын их сургуульд Докторын зэргээ хамгаалсан ба англи, франц, орос, польш хэлээр чөлөөтэй харилцдаг.

Виллиам Б.Бартон

Бартон нь 1990 онд үүсгэн байгуулагдсан геологийн болон байгалийн нөөцийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хувьцаат компаниудад менежментийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг компани болох Бедфорд Ресорсис Менежмент Инк-ийн Ерөнхийлөгчөөр ажиллаж байсан.Бартон нь 1973 онд Халифаксын Далхоусе их сургуулийг геологийн мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгссөн.Одоо тэрээр Нью Брунсуикд байрлах Моунт Плеасант полиметалын уурхайн ашиглалтыг хариуцаж буй Адекс Майнинг Инк-ийн Үүсгэн байгуулагч, Захирлаар ажиллаж байгаа бөгөөд ашигт малтмалын хайгуул, ашиглалтын үйл ажиллагааны талаар Канадын хэд хэдэн хувьцаат компанид гүйцэтгэх албан тушаал хашиж байна.Бартон нь ашигт малтмалын салбарт геологич болон гүйцэтгэх удирдлагаар ажиллаж байсан 40 гаруй жилийн туршлагатай.1996-1998 оны хооронд тэрээр Монгол Улс болон Төв Азид олон улсын алтны нөөцийг тогтоох хайгуулын компанийн Ерөнхий захирлаар, 1996-1997 оны хооронд Монголын Гоулдфилдс Корпорацийн Ерөнхийлөгчөөр ажиллаж байсан.Сүүлд Бүгд Найрамдах Конго Улсын Карналитийн ордын хайгуул

болон уурхайн ашиглалтын ажлаас хойш Поташийн уурхайн үйл ажиллагааг хөгжүүлэх техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж буй МагИндастриэс корпорацийн Үүсгэн байгуулагч, Ерөнхийлөгч, Гүйцэтгэх захирлын албыг хашиж байна. Бартон нь “Компанийн захирлуудын институт”-ийн гишүүн бөгөөд “Аудитын Хорооны үр ашигтай байдал” курсыг 2012 оны 12-р сард дүүргэсэн.

Жон П. Бюрн

Бюрн нь хөрөнгө оруулалтын банк болон компанийн санхүүжилтийн чиглэлээр ажилласан 30 гаруй жилийн туршлагатай бөгөөд одоогийн байдлаар газрын тос, хийн хайгуулын болон ашиглалтын Канад Эксплорейшн Лимитэд (Фетрекс)-ийн Газрын тосны корпорацийн Захирлаар 1976 оноос хойш ажиллаж байна. Фетрекс нь Бюрнийн дэд захирлаар ажиллаж байсан (1986-2000) Энерплас Энержи Сервисэс Лимитэд-ийн үүсгэн байгуулалт болон санхүүжилтэд туслалцаа үзүүлсэн. Тэрээр Левеск Бейубиэнтэй хамтран Геоффрин Инк (одоогийн Үндэсний Санхүүгийн Банк), А.Е.Амес & Компани Лтд/Доминион Секуритис Амес Лтд болон Фирст Бостон Корпорацид удирдах албан тушаал хашиж байсан. Бюрн нь Макгиллийн их сургуульд бизнесийн удирдлага мэргэжлээр бакалаврын зэрэг хамгаалсан бөгөөд Торонтогийн хуулийн их сургуульд хууль зүйн ухааны бакалаврын зэрэг эзэмшсэн. Мөн тэрээр мэргэшсэн санхүүгийн шинжээч бөгөөд одоогийн байдлаар Мориен Ресорсис Корпорейшний (TSX-V) Захирлаар ажиллаж байна.

Ж.К. (Крис) Кован

Кован нь геологийн шинжлэх ухааны магистр, мэргэшсэн инженер (Онтарио) зэрэгтэй бөгөөд 1990 оноос хойш хайгуулын болон уул уурхайн компаниудад ашигт малтмалын зөвлөх үйлчилгээг үзүүлсээр ирсэн. Үүнээс өмнө тэрээр Фалконбридж Лимитэд компанид 28 жилийн турш удирдлагын түвшний болон төлөөлөн удирдах зөвлөлийн хэд хэдэн ажил эрхэлж байсан. Кован нь Фалконбриджийн олон улсын хайгуулын ажлуудад техникийн чиглэл өгч, Өмнөд Азийн бүс нутгийн ажилд хайгуулын менежер болон “Сэдбүри” төсөлд геологийн хэлтсийн Захирлын албыг тус тус хашдаг. Кован нь ЭРД-ийн үүсгэн байгуулагчдын нэг бөгөөд 2006 оноос 2015 оны 6-р сарыг хүртэл Дэд захирлаар (Ази) мөн 2015 оны 6-р сард Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Даргаар сонгогдон ажиллаж байсан. Кован нь Юниголд Инк (2003-2006), Престон Ресорсиз Инк. (1997-2001), Адвансед Праймари Минералс Корпораци (2008-2012) зэрэг дэлхийн хэмжээний хувьцаат компаниудын Захирлаар ажиллаж байсан.

Т. Лейтон Крофт

Крофт нь Оюу толгой ХХК-д Компанийн дотоод хэрэг, Нийгмийн хариуцлагын (Монгол) хэлтсийн Гүйцэтгэх дэд захирал, СаусГоби Энержи Ресорсис-д Гадаад хэрэг, Компанийн харьяалын (Хонг Конг) хэлтсийн Дэд захирал, Азийн Сангийн Төлөөлөгч (Монгол), 2011-ээс 2015 оны хооронд Пибоди Энержигийн Азийн бүсийн (Сингапур) Гадаад харилцааны хэлтсийн Дэд захирлаар, Азийн бүс тэр дундаа Монгол Улсад төвлөрөн ажиллаж байсан 12 гаруй жилийн туршлагатай. Крофт нь 2017 оны 1-р сард Панконтинентал Голд Корпорацийн (Панкон Голд) Компанийн хөгжлийн хэлтсийн Дэд захирлаар 2017 оны 1-р сард, 2017 оны 3-р сард Панкон Голдын Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнээр тус тус томилогдсон. Панкон Голд

нь Америкийн Нэгдсэн Улсын зүүн өмнөд хэсэгт уул уурхайн үйл ажиллагаа явуулдаг, Торонтогийн хөрөнгийн биржид бүртгэлтэй Канадын компани юм.1994 оноос эхлэн нийт 15 жилийн турш Монгол Улсад ажиллаж, амьдарсны хувьд Крофт нь Монголын бизнес, улс төр, нийгэм, соёлын талаар гүнзгий мэдлэгтэй.АНУ-ын уугуул Крофт нь Ази, Латин Америк, Өмнөд Европд хувийн хэвшилд ажиллаж амьдарсан 22 жилийн туршлагатай.Крофт нь Чапел Хилл дэх Өмнөд Каролинагийн их сургуульд бакалавр, Вермунтийн Олон улсын Трейнинг сургуульд магистр, Массачүсетсийн Тафс их сургуулийн Флетчерийн Хууль, Дипломатын их сургуульд магистрын зэрэг хамгаалсан.

Кеннет В. МакДоналд

МакДоналд нь 2003 оны 3-р сараас хойш ЭРД-ийн Санхүү эрхэлсэн захирал, Дэд захирлаар ажиллаж байгаа бөгөөд 2003 оны 3-р сараас 6-р сар хүртэл ЭРД-ийн Захирлаар ажиллаж байсан. 2009 оны 2-р сарын 27-нд Бета Минералс Инк.-ийг ЭРД худалдаж авмагц Макдоналд нь Адвенсед Праймари Минералс Корпорацийн (АПМ) Ерөнхийлөгч, Гүйцэтгэх захирлаар томилогдсон.2012 оны 11-р сард АПМ болон Эрдэнэ Ресорсиз Инк компаниуд нэгдэж Мориен Ресорсиз Корпарейшнийг (Мориен) байгуулахад Макдоналд нь Санхүүгийн хэлтсийн Дэд захирлаар томилогдсон.МакДоналд нь 2016 оны 6-р сарын 30-нд Мориений Санхүүгийн хэлтсийн Захирлын албан тушаалаас бууж ЭРД-ийн Дэд ерөнхийлөгч, Санхүүгийн хэлтсийн Захирлаар томилогдсон.1992 оноос өдийг хүртэл МакДоналд нь Пишер Транспорт Лимитэд тээврийн компанийн Ерөнхийлөгчөөр ажиллаж байна. МакДоналд нь Каоклей Ресорсиз Инк.-ийн Санхүүгийн хэлтсийн Дэд захирал, Санхүүгийн хэлтсийн Захирлаар, 1996 оноос дээрх компанийг ЭРД-д нэгтгэх хүртэл буюу 2006 оны 6-р сар хүртэл ажилласан. 1985-аас1992 оны хооронд ашигт малтмалын салбарт үйл ажиллагаа явуулдаг төрийн болон хувийн хэвшлийн компаниудад санхүүгийн хэлтсийн дэд захирал, захирлаар ажиллаж байсан.1985 оноос өмнө МакДоналд нь Канадын томоохон аудитийн компанид Ахлах менежерийн албан тушаал эрхэлж байсан, мэргэшсэн нягтлан бодогч юм.

Дэвид В. Мошер

Мошер нь ашигт малтмалын чиглэлээр олон улсад 35 жилийн туршлага хуримтлуулсан мэргэжилтэн юм.1992-2008 оны хооронд, Мошер нь Канад, Африк, Оросын алтны үйлдвэр, олборлолт, хайгуулын үйл ажиллагаа эрхэлдэг, Торонтогийн хөрөнгийн биржид бүртгэлтэй компани болох Хай Ривер Гоулд Майнес Лтд-ийн Ерөнхийлөгч, Гүйцэтгэх захирлын албан тушаалыг хашиж байсан. Тус ажлын хүрээнд тэрээр Оросын Холбооны Улсын алтны хоёр компанийг нэгтгэх хэлэлцээрийг хийсэн бөгөөд Буркино Фасогийн засгийн газартай уул уурхайн хөрөнгө оруулалтын гэрээг байгуулж, компанийн нийт хөрөнгийг 300 сая ам.долларт хүргэж, хоёр ч алтны уурхайн компанид (Буркино Фасогийн Тапарко алтны уурхай, ОХУ-ын Березотови алтны уурхай) зөвлөгөө өгч ажиллаж байсан. Тэрээр Камбиор Инк зэрэг олон компанийн төлөөлөн удирдах зөвлөлд ажиллаж байсан ба ажил, мэргэжлийнхээ эхний жилүүдэд Панконтинентал Майнинг Лимитэд компанийн төслийн менежерээр ажиллаж байсан, түүний ажиллаж байсан баг тухайн үеийнхээ хамгийн том ураны нөөцийг илрүүлсэн (Жабилука нь Австрали тивийн хойд хэсэгт оршдог).Сүүлийн арван жилд Мошер нь төрийн болон хувийн олон тооны шинэ компаниудын зохион байгуулалт, санхүүжилтийн асуудлаар төсөл хэрэгжүүлж

байгаа бөгөөд Панконтинентал Ураниум Корпорейшн (TSX-V) болон Пелангио Эксплорейшн Инк (TSX-V) зэрэг уул уурхай, хайгуулын компаниудын захирлаар ажиллаж байна. Мошер нь Акадиагийн их сургуульд геологийн мэргэжлээр бакалаврын зэрэг хамгаалсан.

Канадын хуульчийн ирүүлсэн дүгнэлт, ЭРД-ийн Дүрэм болон 2017 оны 6-р сарын 14-ний өдрийн ЭРД-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол зэрэгтэй танилцсаны үндсэн дээр дүгнэхэд ЭРД-ийн удирдлагын багийн гишүүдийн эрх хэмжээ, томилгоо нь хууль ёсны, хүчин төгөлдөр байна. Канадын Дүгнэлтэд дурдсаны дагуу ЭРД-ийн удирдлагын багийн захирал, ажилтан нь сүүлийн нэг жилийн хугацаанд ямар нэг шүүхийн эсвэл үнэт цаасны зохицуулах байгууллагын шийдвэрээр үнэт цаасны зах зээлтэй холбоотой хууль тогтоомжийг зөрчсөн үйлдэл хийсэн гэж тогтоогдоогүй, үнэт цаасны зохицуулагч байгууллагатай ямар нэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх хэлцэлд оролцоогүй, мөн тэдэнд шүүхээс өөр бусад ямар нэг хэрэгт хариуцлага хүлээлгэсэн шийдвэр гаргаагүй байна.

2.2. ЭМ болон АР-ын удирдлагын багийн эрх хэмжээ

А. Удирдлагын бүтэц

1) Хувьцаа эзэмшигчдийн хурал

Компанийн хуулийн дагуу компанийг удирдах дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал эсвэл хувьцаа эзэмшигч (100 хувийн нэг этгээд эзэмших тохиолдолд) байна. ЭМ-ын Дүрэм болон АР-ын Дүрмийн 11 дүгээр зүйлд мөн Хувьцаа эзэмшигчдийн хурал нь эрх барих дээд байгууллага байхаар заасан байна.

ЭМ-ын Дүрэм болон АР-ын Дүрэмд заасны дагуу ЭМ болон АР тус бүрийн хувьцаа эзэмшигч нь Компанийн хуулийн 34 дүгээр зүйлд¹⁵ заасан эрхийг эдэлнэ.

ЭМ-ын Дүрэм болон АР-ын Дүрмийн 13 дугаар зүйлд Хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлыг шийдвэрлэхээр заасан байна:

- Дүрэмд оруулах аливаа нэмэлт, өөрчлөлтийг, эсхүл Компанийн дүрмийг шинэчлэн батлах;
- Компанийг нэгтгэх, нийлүүлэх, хуваах эсхүл өөрчлөх замаар өөрчлөн зохион байгуулах;
- Компанийн өрийг Хувьцаагаар солих, нэмэлт хувьцаа гаргах, хувьцааны тоог тодорхойлох;
- Компанийг татан буулгах, татан буулгах комисс томилох;
- Хувьцааг хуваах эсвэл нэгтгэх; мөн
- Компанийн тухай хуулийн 12 дугаар бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах.

2) Төлөөлөн удирдах зөвлөл¹⁶

¹⁵Энгийн хувьцаа эзэмшигчийн эрх, Компанийн тухай хуулийн 34 дүгээр зүйл

¹⁶“Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн Удаирдах Зөвлөл байна”, Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1

ЭМ болон АР нь өөрсдийн тус бүрийн Дүрмээр гурван (3) гишүүнээс бүрдсэн Төлөөлөн Удирдах Зөвлөлтэй байхаар тогтоосон бөгөөд одоогийн ТУЗ-ын дараах гишүүдийг хувьцаа эзэмшигч болох ЭРД-ийн 2017 оны 5-р сарын 7-ны өдрийн шийдвэрээр томилсон байна¹⁷ :

- Петер С. Акерли,
- Багабандийн Баярмаа, мөн
- Анхбаярын Билгүүн.

ЭМ болон АР-ын тус тусын дүрмээр ТУЗ-д тусгайлсан эрх олгоогүй тул ЭМ болон АР-ын ТУЗ нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлд заасан эрх хэмжээг хэрэгжүүлнэ.

3) Хууль ёсны төлөөлөгч – Гүйцэтгэх захирал¹⁸

ЭМ болон АР-ын тус бүрийн Дүрмийн 21 дүгээр зүйлд компанийн хууль ёсны төлөөлөгч болох Ерөнхий захирлыг ТУЗ-аас томилж, Ерөнхий захирал нь компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж ТУЗ-д тайлагнахаар заасан байна.

ЭМ-ын Улсын Бүртгэлийн Гэрчилгээ болон ХЭБГ-аас ирүүлсэн 00282422 тоот Тодорхойлолтоос харахад Петер С. Акерли нь компанийн хууль ёсны төлөөлөгч буюу Ерөнхий захирал (Гүйцэтгэх захирал)-аар бүртгэгдсэн байна.

АР-ын Улсын Бүртгэлийн Гэрчилгээ болон ХЭБГ-аас ирүүлсэн 00282423 тоот Тодорхойлолтоос харахад Петер С. Акерли нь компанийн хууль ёсны төлөөлөгч буюу Ерөнхий захирал (Гүйцэтгэх захирал)-аар бүртгэгдсэн байна.

Дээрх мэдээлэл болон бидэнд ирүүлсэн баримтуудад үндэслэн дүгнэвэл ЭМ болон АР-ын тус тусын ТУЗ болон гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэгч этгээдүүд нь Компанийн хууль болон тус тусын дүрэмд заасан эрх, үүргийг хэрэгжүүлэх бүрэн эрхтэй, тэднийг томилсон шийдвэрүүд нь энэхүү Дүгнэлтийг гаргах өдрийн байдлаар хүчин төгөлдөр байна.

2.3. ЛЭ-ийн удирдлагын багийн эрх хэмжээ

А. Удирдлагын бүтэц

1) Хувьцаа эзэмшигчдийн хурал

ЛЭ-ийн Дүрмийн 11 дүгээр зүйлд заасны дагуу компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байна.

¹⁷“Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас томилно”, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7

¹⁸“Төлөөлөн удирдах зөвлөл нь гүйцэтгэх удирдлагыг сонгож, томилно”, Компанийн тухай хуулийн 76-р зүйлийн 76.1.8

ЛЭ-ийн Дүрмийн 10 дугаар зүйлд заасны дагуу компанийн энгийн хувьцаа эзэмшигчид нь Компанийн хуулийн 34 дүгээр зүйлд заасан эрхийг эдэлнэ.

ЛЭ-ийн Дүрмийн 13 дугаар зүйлд заасны дагуу дараах асуудлуудыг зөвхөн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар оруулж шийдвэрлүүлнэ:

- Дүрэмд оруулах аливаа нэмэлт, өөрчлөлтийг, эсхүл Компанийн дүрмийг шинэчлэн батлах;
- Компанийг нэгтгэх, нийлүүлэх, хуваах эсхүл өөрчлөх замаар өөрчлөн зохион байгуулах;
- Компанийн өрийг Хувьцаагаар солих, нэмэлт хувьцаа гаргах, хувьцааны тоог тодорхойлох;
- Компанийг татан буулгах, татан буулгах комисс томилох;
- Хувьцааг хуваах эсвэл нэгтгэх;
- XV-016057 дугаартай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг шилжүүлэх болон худалдах; мөн
- Компанийн тухай хуулийн 12-р бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах.

2) Хувьцаа эзэмшигчдийн зөвлөх хороо

ЛЭ-ийн Дүрмийн 16 дугаар зүйлд заасны дагуу ЛЭ нь түүний хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийг хянаж, батлах үндсэн чиг үүрэгтэй, дараах таван (5) гишүүнээс бүрдсэн Хувьцаа эзэмшигчдийн зөвлөх хороо (Хороо)-г 2017 оны 8-р сарын 18-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор томилсон байна. Үүнд:

- Петер С. Акерли;
- Багабандийн Баярмаа;
- Анхбаярын Билгүүн;
- Задрагчаагийн Эрдэнэчулуун; мөн
- Задрагчаагийн Эрдэнэхуяг.

ЛЭ-ийн Дүрмийн 17 болон 18 дугаар зүйлд дурдсанаар Хорооны гишүүдийг тодорхойгүй хугацаагаар томилох бөгөөд хувьцаа эзэмшигчдийн хурлаас дараагийн гишүүдийг томилох хүртэл бүрэн эрхээ хэрэгжүүлнэ. Хороо нь жилд хоёроос доошгүй удаа хуралдана.

3) Хууль ёсны төлөөлөгч – Гүйцэтгэх захирал

ЛЭ-ийн Дүрмийн 22 дугаар зүйлд заасны дагуу компанийн Гүйцэтгэх захирлыг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас томилох бөгөөд Гүйцэтгэх захирал ажлаа хувьцаа эзэмшигчдэд тайлагнана.

ЛЭ-ийн Улсын Бүртгэлийн Гэрчилгээ болон ХЭБГ-аас ирүүлсэн 00282424 тоот Тодорхойлолт болон 2017 оны 8-р сарын 18-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоос үзэхэд Анхбаярын Билгүүн нь компанийн хууль ёсны төлөөлөгч буюу Гүйцэтгэх захирлаар бүртгэгдсэн байна.

Дээрх мэдээлэл болон бидэнд ирүүлсэн баримтуудад үндэслэн дүгнэвэл ЛЭ-ийн Хувьцаа эзэмшигчдэд зөвлөх хороо болон гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэгч этгээдүүд нь Компанийн хууль болон тус тусын дүрэмд заасан эрх, үүргийг хэрэгжүүлэх бүрэн эрхтэй, тэднийг томилсон шийдвэрүүд нь энэхүү Дүгнэлтийг гаргах өдрийн байдлаар хүчин төгөлдөр байна.

ГУРАВ. ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ

1.1. ЭРД-ийн хийсэн томоохон хэлцлүүд

Канадын хуульчийн тодорхойлсноор дараах гэрээг ЭРД-ийн томоохон хэлцлүүд гэж үзэж байна. Үүнд:

1) 2013 оны 4-р сарын 11-ний өдөр Тек Ресурс Лимитэд (Тек) компанитай байгуулсан Стратегийн түншлэлийн гэрээ

Түншлэлийг Монгол Улсын баруун өмнөд зүгийн Транс Алтай бүсэд байрладаг ЭРД-ийн ашигт малтмалын талбайг санхүүжүүлэх болон хайгуул хийхийн тулд опцион болон хаалттай хүрээнд хөрөнгө татан төвлөрүүлэх гэрээ (**ЭРД-Тек гэрээ**)-ний дагуу байгуулсан.

ЭРД-Тек гэрээний нөхцөлийн дагуу Тек нь 3 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийх хүртлээ эсхүл зарласан энгийн хувьцааны 19.9 хувийг эзэмших хүртлээ (эдгээрийн аль түрүүлж бий болсон нөхцөлд) ЭРД-ийн хувьцааны 10 (арван) өдрийн арилжааны жигнэсэн дундаж ханш дээр 10 (арван) хувийг нэмж үнэ тогтоон жил тутам, брокероор зуучлуулахгүйгээр, хаалттай хүрээнд хөрөнгө татан төвлөрүүлэх энгийн хувьцаа захиалж эзэмшихээр тохиролцсон.

ЭРД-Тек гэрээний дагуу ЭРД нь 2013 оны 4-р сарын 23-ны өдрөөс эхлэн 2017 оны 3-р сарын 21-ний өдрийг дуустал хугацаанд дараах байдлаар хувьцаа гаргаж хаалттай хүрээнд хөрөнгө татан төвлөрүүлээд байна:

№	Хувьцаа гаргасан огноо	Энгийн хувьцааны тоо	Нэрлэсэн үнэ /ам.доллар/	Нийт орлого /ам.доллар/
1	2013 оны 4-р сарын 23	5'000'000	0.20	1'000'000
2	2013 оны 11-р сарын 7	2'142'857	0.07	150'000
3	2014 оны 4-р сарын 21	2'000'000	0.175	350'000
4	2015 оны 4-р сарын 27	2'826'310	0.139	392'857
5		1'071'429	0.10	107'143
6	2016 оны 6-р сарын 6	1'063'830	0.47	500'000
7	2017 оны 3-р сарын 21	543'487	0.92	500'000
				3'000'000

2013 оны 4-р сарын 11-ний өдөр олон нийтэд мэдэгдсэн ЭРД-Тек гэрээний дагуу хаалттай хүрээнд хөрөнгө татан төвлөрүүлэхтэй холбоотой Текийн хөрөнгө

оруулалтын үүрэг (3 сая ам.доллар) 2017 оны 3-р сарын 21-ний өдөр биелэгдсэн байна¹⁹.

2) Сандсторм Гоулд Лтд. (Сандсторм) компанитай 2016 оны 3-р сард байгуулсан Хувьцаа захиалгын гэрээ

ЭРД-ийн Захирлуудын Зөвлөлөөс, 2016 оны 3-р сарын 18-ний өдрийн огноотой, 2016 оны 3-р сарын 21-ний өдөр байгуулсан үүрэг үл хүлээлгэх урьдчилсан хэлцлийн нөхцөлийн дагуу Сандстормтой Хувьцаа захиалгын гэрээ байгуулах тухай тогтоол гаргасан.

Эхний хэлцлээр, Сандстормын 1'500'000 ам.долларын үнэ бүхий 321'888 ширхэг хувьцааны хариуд ЭРД-ийн Цэнхэр Номин болон Хөндий нэртэй газар эзэмшдэг тусгай зөвшөөрөлд 2 хувийн борлуулалтын цэвэр ашгийн төлбөр (Борлуулалтын цэвэр ашгийн төлбөр) Сандстормд ирээдүйд хуваарилахаар тохирсон бөгөөд хувьцааны үнийг тогтоохдоо 2016 оны 4-р сарын 14-ний өдрийн байдлаарх 10 өдрийн арилжааны жигнэсэн дундаж ханшид үндэслэжээ.

Хоёр дахь хэлцлээр, бэлнээр төлсөн 1'000'000 ам.долларт нэгж хувьцааг 0.20 ам.доллараар тооцон 5 сая ширхэг Энгийн хувьцааг ЭРД-ээс Сандстормд олгосон. Сандстормд олгосон Энгийн хувьцаа нь 2017 оны 10-р сарын 14-ны өдөр дуусгавар болох 18 сарын үргэлжилсэн хугацаатай. ЭРД нь Борлуулалтын цэвэр ашгийн төлбөрийг 1.0 хувьд хүргэж бууруулахын тулд 1.2 сая ам.долларын Борлуулалтын цэвэр ашгийн төлбөрийн 50 хувийг буцаан худалдан авах 3 жилийн хугацаа бүхий опционтой²⁰.

Канадын дүгнэлтэд үндэслэн, дээр дурдсан ЭРД-ийн томоохон хэлцлүүдийг Канадын үйлчилж буй хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор байгуулсан бөгөөд ЭРД-ийн Захирлуудын Зөвлөл нь томоохон хэлцлүүд байгуулах тухай холбогдох шийдвэр, тогтоол гаргасан гэдгийг баталгаажуулж байна.

1.2. ЭМ-ын хийсэн томоохон хэлцлүүд

ЛЭ-ийн Хувьцааг худалдан авах хэлцлээс бусдаар, ЭМ нь 2017 онд ямар нэг их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгээгүй байна. Тус хэлцлийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү Дүгнэлтийн 5.2-т оруулсан болно.

2016 оны 12-р сарын 15-ны өдөр үйлдсэн ЭМ-ын Дүрмийн 13(e) хэсэгт, сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулахыг зөвхөн Хувьцаа эзэмшигчдийн бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэхээр заасан байна. Энэ нь Компанийн тухай хуульд нийцэж байна.

¹⁹2017 оны 3-р сарын 27-нд гаргасан, 2016 оны 12-р сарын 31-ээр дуусгавар болж буй санхүүгийн жилд хамаарах Жилийн тайлан, 7-р хуудас

²⁰2017 оны 3-р сарын 27-нд гаргасан, 2016 оны 12-р сарын 31-ээр дуусгавар болж буй санхүүгийн жилд хамаарах Жилийн тайлан, 8-р хуудас

Их хэмжээний хэлцлийн хувьд, Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс их хэмжээний хэлцэл байгуулахыг шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Хувьцаа эзэмшигчдийн хурлаар их хэмжээний хэлцлийг батална²¹.

Бидэнд гаргаж өгсөн гэрээний жагсаалтад үндэслэн ЭМ нь 2017 онд ложистикийн, харуул хамгаалалтын, хууль зүйн, аудитын, өрөмдлөгийн үйлчилгээний, геологийн ажлын, хариуцлагын болон гэнэтийн ослын даатгалын зэрэг үндсэн үйл ажиллагаатайгаа холбоотой нийт 28 гэрээ байгуулсан байна. 2017 онд төлсөн гэрээний нийт үнийн дүнг дараах байдлаар харуулж болохоор байна. Үүнд:

- 1'000'000'000 төгрөгөөс дээш – 1 гэрээ;
- 100'000'000 – 1'000'000'000 төгрөг – 5 гэрээ;
- 50'000'000 – 100'000'000 төгрөг – 5 гэрээ;
- 10'000'000 – 50'000'000 төгрөг – 9 гэрээ;
- 5'000'000 – 10'000'000 төгрөг – 2 гэрээ;
- 1'000'000 – 5'000'000 төгрөг – 5 гэрээ;
- 1'000'000 хүртэлх төгрөг – 1 гэрээ.

ЭМ-ын эдгээр 28 гэрээг ЭМ-ын харилцан хамааралтай этгээдүүдтэй байгуулаагүй бөгөөд ЭМ-ын 2016 оны 12-р сарын 31-ний байдлаарх санхүүгийн тайлангийн дагуу хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас доош зах зээлийн үнэтэй байгаа тул гэрээнүүдийг их хэмжээний хэлцэл буюу сонирхлын зөрчилтэй хэлцлийн аль аль нь биш гэж үзэж байна.

1.3. АР-ын хийсэн томоохон хэлцлүүд

АР нь 2017 онд ямар нэг их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгээгүй байна.

2016 оны 12-р сарын 15-ны өдөр үйлдсэн АР-ын Дүрмийн 13(е) хэсэгт, сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулахыг зөвхөн Хувьцаа эзэмшигчдийн бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэхээр заасан байна. Энэ нь Компанийн тухай хуульд нийцэж байна.

Их хэмжээний хэлцлийн хувьд, Компанийн тухай хуульд заасны дагуу Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс их хэмжээний хэлцэл байгуулахыг шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Хувьцаа эзэмшигчдийн хурлаар их хэмжээний хэлцлийг батална.

Бидэнд гаргаж өгсөн гэрээний жагсаалтын дагуу АР нь 2017 онд хууль зүйн болон аудитын үйлчилгээний зэрэг үндсэн үйл ажиллагаатайгаа холбоотой нийт 3 гэрээ байгуулсан байна. 2017 онд төлсөн гэрээний нийт үнийн дүнг дараах байдлаар харуулж болохоор байна. Үүнд:

- 5'000'000 – 10'000'000 төгрөг – 1 гэрээ;
- 1'000'000 – 5'000'000 төгрөг – 1 гэрээ;
- 1'000'000 хүртэлх төгрөг – 1 гэрээ.

АР-ын эдгээр 3 гэрээг АР-ын харилцан хамааралтай этгээдтэй байгуулаагүй бөгөөд АР-ын өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбоотой тул гэрээнүүдийг их

²¹Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.10

хэмжээний хэлцэл буюу сонирхлын зөрчилтэй хэлцлийн аль аль нь биш гэж үзэх боломжтой байна.

1.4. ЛЭ-ийн хийсэн томоохон хэлцлүүд

ЛЭ нь 2017 онд ямар нэг их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгээгүй байна.

2017 оны 8-р сарын 18-ны өдөр үйлдсэн ЛЭ-ийн Дүрмийн 13(ё) хэсэгт, сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулахыг зөвхөн Хувьцаа эзэмшигчдийн бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэхээр заасан байна. Энэ нь Компанийн тухай хуульд нийцэж байна.

Их хэмжээний хэлцлийн хувьд, Компанийн тухай хуульд заасны дагуу Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс их хэмжээний хэлцэл байгуулахыг шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Хувьцаа эзэмшигчдийн хурлаар их хэмжээний хэлцлийг батална.

Бидэнд гаргаж өгсөн гэрээний жагсаалтын дагуу ЛЭ нь 2017 онд ложистикийн, аудитын, сорьц, дээж авах үйлчилгээний болон геологийн ажлын зэрэг үндсэн үйл ажиллагаатайгаа холбоотой нийт 4 гэрээ байгуулсан байна. 2017 онд төлсөн гэрээний нийт үнийн дүнг дараах байдлаар харуулж болохоор байна. Үүнд:

- 50'000'000 – 100'000'000 төгрөг – 2 гэрээ;
- 5'000'000 – 10'000'000 төгрөг – 1 гэрээ;
- 1'000'000 – 5'000'000 төгрөг – 1 гэрээ.

ЛЭ-ийн эдгээр 4 гэрээг ЛЭ-ийн харилцан хамааралтай этгээдүүдтэй байгуулаагүй бөгөөд ЛЭ-ийн 2016 оны 12-р сарын 31-ний байдлаарх санхүүгийн тайлангийн дагуу хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас доош зах зээлийн үнэтэй байгаа тул гэрээнүүдийг их хэмжээний хэлцэл буюу сонирхлын зөрчилтэй хэлцлийн аль аль нь биш гэж үзэх боломжтой байна.

ДӨРӨВ. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

2.1. ЭРД-ийн тусгай зөвшөөрлүүд

ЭРД нь нийт 11,820 га талбай бүхий дөрвөн (4) хайгуулын тусгай зөвшөөрөл болон 6,041 га талбай бүхий нэг (1) ашиглалтын тусгай зөвшөөрөл (**ЭРД-ийн Тусгай зөвшөөрлүүд**)-ийг Монгол Улс дахь өөрийн охин компани болох ЭМ, АР болон ЛЭ-ийн нэр дээр эзэмшдэг болно.

ЭРД нь Монгол Улсад дараах томоохон төслийг хэрэгжүүлж байна:

- Баян Хөндий Алтны төсөл (Хөндий тусгай зөвшөөрлийн талбайд байрлана);
- Алтан Нар Алт-Полиметалийн төсөл (Цэнхэр номин тусгай зөвшөөрлийн талбайд байрладаг)

- Бургаст (Говь-Алтай аймагт);
- Зуунмод Молибдени-Зэсийн төсөл (Хөвийн хар тусгай зөвшөөрлийн талбайд байрлана);
- Хөвийн Хар Зэс Порфирийн төсөл (ЭРД-Тек Түншлэлийн хамтын ашиг сонирхлын талбайгаас 2014 онд гарсан, Хөвийн Хар тусгай зөвшөөрлийн талбайд байрлана);
- Улаан Зэс Алт Порфирийн төсөл (ЭРД нь 2017 онд Баян Хөндий Алтны төсөлд нэмэлтээр Улаан хайгуулын тусгай зөвшөөрлийн 51 хувийг шилжүүлж авсан).

Тусгай зөвшөөрлүүдийн дэлгэрэнгүй мэдээллийг удаах хэсгүүдэд оруулав.

Канадын хуулийн фирмийн ирүүлсэн Канадын дүгнэлт дэх мэдээлэл, тодорхойлолтын дагуу ЭРД нь Канадад аливаа тусгай зөвшөөрөл, гэрчилгээ, оюуны өмчийн эрх, барааны тэмдэг эзэмшдэггүй бөгөөд ЭРД-ийн үйл ажиллагаа нь Канадын хууль тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллагуудаас ямар нэгэн зөвшөөрөл шаарддаггүй болно. Түүнчлэн Канадын хуульч нь ЭРД-ийн хувьд ТХБ-д тайлагнахаас бусад бүртгүүлэх, тайлагнах шаардлага Канадын хууль тогтоомжийн дагуу байхгүй болохыг баталгаажуулсан байна.

ЭРД нь ТХБ-д бүртгэлтэй бөгөөд Канадын Үнэт цаасны холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулдаг. Канадын хуульчаас ирүүлсэн Канадын дүгнэлтэнд тодорхойлсноор ЭРД нь ТХБ-ийн бүртгүүлэх болон мэдээлэл, тодруулгаар хангаж байх шаардлагуудад нийцэж ажиллаж байна.

2.2. ЭРД-ийн Тусгай зөвшөөрлүүдийн хүчин төгөлдөр байдал

А. ЭМ-ын эзэмшиж буй ашигт малтмалын тусгай зөвшөөрөлүүд

ЭМ²² нь нийт 10'039 га талбай бүхий гурван (3) ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшиж байна.

1. Баянхонгор аймгийн Баян-Өндөр болон Шинэжинст сумын Хөндий нэртэй газар байрлах XV-015569 дугаартай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг АМГ-ын Геологи, Уул уурхай, Кадастрын Хэлтсийн (ГУУКХ) даргын 2010 оны 3-р сарын 31-ний өдрийн 389 тоот тушаалаар ЭМ-д олгосон бөгөөд уг тусгай зөвшөөрөл нь 2019 оны 4-р сарын 14-ний өдөр хүртэл хүчинтэй байна (**Хөндий Тусгай зөвшөөрөл**).
2. Баянхонгор аймгийн Баян-Өндөр болон Шинэжинст сумын Цэнхэр Номин нэртэй газар байрлах XV-016956 дугаартай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн 4668.64 га талбайг анх 2009 оны 12-р сарын 11-нд олгож, 2012

²²“Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Ашигт Малтмалын хууль болон холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хайгуулын талбайн хилийн дотор энэ хуулийн дагуу ашигт малтмал эрэх, хайх, хайгуулын талбайн аль ч хэсэгт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлийг онцгой эрхийнхээ дагуу авах, ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөлийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн бусдад шилжүүлэх, барьцаалах, хайгуулын талбайд нэвтрэн орохын тулд хайгуулын талбайн гаднах газар нутгаар дамжин өнгөрөх, талбайг бүхэлд, нь эсхүл хэсэгчлэн буцаан өгөх эрхтэй”, Ашигт малтмалын тухай хуулийн 21 дүгээр зүйл

оны 12-р сарын 11-нд дууссан хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайгаас тусгаарлаж, АМГ-ын ГУУКХ-ын даргын 2011 оны 11-р сарын 24-ний өдрийн 1076 тоот тушаалаар ЭМ-д олгосон бөгөөд уг тусгай зөвшөөрөл нь 2018 оны 12-р сарын 11-ний өдөр хүртэл хүчинтэй байна (**Цэнхэр Номин Тусгай зөвшөөрөл**).

3. Говь-Алтай аймгийн Цогт сумын Бургаст нэртэй газар байрлах XV-017875 дугаартай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг АМГ-ын Кадастрын хэлтсийн даргын 2015 оны 6-р сарын 02-ны өдрийн 438 тоот тушаалаар ЭМ-д олгосон бөгөөд уг тусгай зөвшөөрөл нь 2018 оны 6-р сарын 08-ны өдөр хүртэл хүчинтэй байна (**Бургаст Тусгай зөвшөөрөл**).

В. АР-ын эзэмшиж буй ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутаг дэвсгэрт байршилтай Хөвийн Хар нэртэй газар байрлах XV-016836 дугаартай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг АМГ-ын ГУУКХ-ийн даргын 2011 оны 5-р сарын 5-ны өдрийн 499 тоот тушаалаар АР-д олгосон бөгөөд уг тусгай зөвшөөрөл нь 2041 оны 5-р сарын 26-ны өдөр хүртэл хүчинтэй байна (**Хөвийн Хар Тусгай зөвшөөрөл**).

Хөвийн Хар Тусгай зөвшөөрлийн талбайд “Зуунмод молибдэни-зэсийн төсөл” болон “Хөвийн харын зэс мөнгөний төсөл” хэрэгжиж байна.

С. ЛЭ-ийн эзэмшиж буй ашигт малтмалын тусгай зөвшөөрөл

Баянхонгор аймгийн Баян-Өндөр болон Шинэжинст сумын Улаан нэртэй газар байрлах XV-015569 дугаартай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг АМГ-ын Кадастрын Хэлтсийн даргын 2010 оны 4-р сарын 13-ны өдрийн 432 тоот тушаалаар ЛЭ-д олгосон бөгөөд уг тусгай зөвшөөрөл нь 2021 оны 2-р сарын 16-ны өдөр хүртэл хүчинтэй байна (**Улаан Тусгай зөвшөөрөл**).

Хүснэгт: ЭРД-ийн Тусгай зөвшөөрлүүдийн мэдээлэл

Тусгай зөвшөөрөл Эзэмшигч	Тусгай зөвшөөрлийн №.	Газрын нэр	Анх олгосон талбай /га/	Одоогийн талбай /га/	Олгосон өдөр	Хугацаа дуусах өдөр	Хайгуулын тусгай зөвшөөрлийн нийт хугацаа дуусах өдөр ²³
ЭМ	XV-015569	Хөндий Баянхонгор аймгийн Баян-Өндөр болон Шинэжинст сум	19936.34	4514.33	2010 оны 4-р сарын 14-ний өдөр	2019 оны 4-р сарын 14-ний өдөр	2022 оны 4-р сарын 14-ний өдөр
ЭМ	XV-016956	Цэнхэр Номин Баянхонгор аймгийн Баян-Өндөр болон Шинэжинст сум	4668.64	4668.64	2011 оны 11-р сарын 24-ний өдөр	2018 оны 12-р сарын 11-ний өдөр	2021 оны 12-р сарын 11-ний өдөр
ЭМ	XV-017875	Бургаст Говь-Алтай аймгийн Цогт сум	857.00	857.00	2015 оны 6-р сарын 08-ны өдөр	2018 оны 6-р сарын өдөр	2027 оны 6-р сарын 08-ны өдөр

²³ “Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөлийг анх олгохдоо 3 жилийн хугацаатай олгодог бөгөөд тусгай зөвшөөрөл эзэмшигч нь зөвшөөрлийн хугацааг 3 жилийн хугацаагаар гурван удаа сунгуулах эрхтэй байдаг байна. Нийт хайгуул хийх хугацаа 12 жил байна”, Ашигт малтмалын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5

					өдөр	08-ны өдөр	
АР	MV-016836	Хөвийн Хар Баянхонгор аймгийн Баян-Өндөр болон Шинэжинст сум	6041.03	6041.03	2011 оны 5-р сарын 26-ны өдөр	2041 оны 5-р сарын 26-ны өдөр ²⁴	N/A
ЛЭ	XV-016057	Улаан Баянхонгор аймгийн Баян-Өндөр болон Шинэжинст сум	1824.18	1780.20	2015 оны 2-р сарын 16-ны өдөр	2021 оны 2-р сарын 16-ны өдөр	2027 оны 2-р сарын 16-ны өдөр

Хянасан баримт бичиг болон АМГ-аас ирүүлсэн Тодорхойлолтын дагуу ЭРД-ийн Тусгай зөвшөөрөлүүд нь Дүгнэлт гаргах өдрийн байдлаар хүчин төгөлдөр байна. ЭРД Тусгай зөвшөөрлүүдийн ээлжит жилийн төлбөрийг зохих журмын дагуу хугацаанд нь бүрэн төлж ирсэн байх ба гүйцэтгээгүй төлбөрийн үүрэг, үлдэгдэл байхгүй болно.

3.1. ЭРД-ийн Тусгай зөвшөөрлүүдэд аливаа барьцаа бүртгэгдсэн эсэх талаар

Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь үйл ажиллагаа явуулахад шаардагдах санхүүжилт олох, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэхийн тулд тусгай зөвшөөрлийг эрэл, хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, геологийн судалгааны мэдээлэл, техник, эдийн засгийн үндэслэл, Монгол Улсын хууль тогтоомжоор барьцаалахыг хориглоогүй хөрөнгийн хамтаар банк, банк бус санхүүгийн байгууллагад барьцаалж болохоор хуульд заасан бөгөөд тусгай зөвшөөрөл нь дангаараа барьцааны зүйл болохгүй.

Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг барьцаалсан бол энэ тухайгаа АМГ-т бүртгүүлнэ²⁵.

АМГ-ын 2018 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 7/758, 7/759 and 7/760 тоот Тодорхойлолтоор ЭРД Тусгай зөвшөөрлүүдийг барьцаалаагүй болохыг баталгаажуулсан байна.

3.1. Хайгуулын ажлын зардлын доод хэмжээг зарцуулсан байдал болон Хөндий, Цэнхэр Номин, Бургаст болон Улаан Тусгай зөвшөөрлүүдийн хайгуулын ажлын төлөвлөгөө, тайланг гаргасан талаарх баталгаажуулалт

Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Ашигт малтмалын хуульд заасан хайгуулын ажлын зардлын хамгийн доод хэмжээнээс багагүй зардал бүхий хайгуулын ажлыг жил бүр хийж гүйцэтгэх үүрэгтэй²⁶ ба хайгуулын зардлын доод хэмжээг АМГ-аар баталгаажуулах ёстой байна.

²⁴ Ашиглалтын лицензийг анх олгохдоо 30 жилийн хугацаатай олгодог бөгөөд лиценз эзэмшигч нь зөвшөөрлийн хугацааг ашигт малтмалын нөөцийн хэмжээнээс хамаарч 20 жилийн хугацаагаар хоёр удаа сунгуулах эрхтэй. Ашигт малтмалын тухай хуулийн 26 дүгээр зүйлийн 26.5 болон 27 дугаар зүйлийн 27.1

²⁵ Ашигт малтмалын тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2

²⁶ Ашигт малтмалын тухай хуулийн 33 дугаар зүйл

АМГ-ын 2018 оны 2-р сарын 01-ний өдрийн 4/757 болон 4/814 тоот Тодорхойлолтоор ЭМ болон ЛЭ нь холбогдох жилүүдэд хайгуулын ажилд хайгуулын ажлын зардлын доод хэмжээгээр зардал гаргаж ажилласан бөгөөд дөрвөн (4) хайгуулын тусгай зөвшөөрлийн хайгуулын ажлын төлөвлөгөө, тайланг тухай бүр АМГ-ын Геологи, Хайгуулын хэлтэст илгээж байсныг баталгаажуулжээ.

Хүснэгт: Хайгуулын ажлын төлөвлөгөө, тайланг илгээсэн байдал

№.	Тусгай зөвшөөрөл эзэмшигч	Тусгай зөвшөөрлийн дугаар	Газрын нэр	Төлөвлөгөө илгээсэн жил	Тайлан өгсөн жил	Хайгуулын ажлын зардлын доод хэмжээ баталгаажуулсан жил
1.	ЭМ	XV-015569	Хөндий	2010-2017	2010-2016	2010-2016
2.	ЭМ	XV-016956	Цэнхэр Номин	2011-2017	2012-2016	2012-2016
3.	ЭМ	XV-017875	Бургаст	2015-2017	2015-2016	2015-2016
4	ЛЭ	XV-016057	Улаан	2015-2017	2015-2016	2015-2016

4.5. Археологи, палентеологийн судалгаа

Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи болон Монгол Улсын Их Сургуулийн 2016 оны 5-р сард хийсэн Археологи, Палентеологийн албан ёсны судалгааны тайланд Цэнхэр Номин (Алтан Нар), Хөндий (Баян Хөндий, Алтан Арроу) дахь тусгай зөвшөөрлийн талбайд археологи, палентеологийн олдвор илрээгүй бөгөөд гадаргын усны хомсдол үүсгэх, бэлчээр талхлагдах, хүний амьдрах орчныг алдагдуулах сөрөг нөлөө үзүүлэхгүй гэж дүгнэжээ.

2012 онд Монголын Үндэсний Их Сургууль Зуун Мод (Хөвийн Хар Тусгай зөвшөөрөл)-ны археологийн судалгааг хийж, тусгай зөвшөөрлийн талбайн хойд, урд болон баруун талаараа археологийн дурсгалууд байх боломжтой гэж дүгнэсэн. Монгол Улсын Шинжлэх Ухааны Академиас хийсэн Зуун Модны палеонтологийн ерөнхий судалгаагаар тухайн бүс нутаг нь ургамал амьтны үлдвэр агуулдаг бөгөөд палеонтологийн сэдэвчилсэн судалгаа хийгдээгүй гэж дүгнэсэн байна.

ЭМ болон ЛЭ-ээс Улаан болон Бургаст Тусгай зөвшөөрлийн талбайд археологи болон палентеологийн судалгаа хийгдээгүй байгаа бөгөөд 2018 онд хийгдэхээр төлөвлөсөн тухай баталгаажуулсан болно.

4.6. Ус ашиглах зөвшөөрөл

Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ус ашиглах хүсэлтийг ашиглах усны хэмжээнээс хамаарч төрийн захиргааны төв байгууллага эсвэл нутгийн захиргааны байгууллагад гаргаж²⁷, ус ашиглуулах дүгнэлтийг гаргуулан ус ашиглах

²⁷Усны тухай хуулийн 26 дугаар зүйл

зөвшөөрлийг авна. Ус ашиглах зөвшөөрөлд үндэслэн ус ашиглах эрх олгож, ус ашиглах гэрээг байгуулдаг.

Ус ашиглах зөвшөөрлийг бусдад шилжүүлэхийг хориглодог бөгөөд бусдад шилжүүлсэн тохиолдолд Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээнэ²⁸.

Хөндий болон Цэнхэр Номин Тусгай зөвшөөрлийн талбайд Баян-Өндөр сумын Засаг даргын А/33 тоот захирамжаар Ус ашиглах зөвшөөрөл олгож, Ус ашиглах гэрээг 2017 оны 4-р сарын 03-ны өдрөөс 2017 оны 12-р сарын 31-ний өдөр хүртэл байгуулсан. ЭМ-ээс уг гэрээ нь шинэчлэгдэх шатандаа явж байгаа гэж мэдэгдсэн.

Хайгуулын ажилд ус шаардагдаагүй болон уурхайг ажиллуулж эхлээгүй тул бусад тусгай зөвшөөрлийн талбайд ус ашиглах зөвшөөрөл аваагүй талаар ЭМ, АР болон ЛЭ-ээс мэдэгдсэн болно.

4.7. Хөвийн Хар Тусгай зөвшөөрлийн Нөөц

Монгол Улсын хувьд ашигт малтмалын хайгуулын үйл ажиллагааны дүнд тодорхойлсон нөөц болон ангиллын мэдээллийг Ашигт малтмалын улсын нөөцийн нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх ёстой байдаг²⁹.

Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашигт малтмалын нөөцийг бүрэн ашиглах үүрэг хүлээх бөгөөд зөвхөн ашиг олох зорилгоор түүнийг сорчлон ашиглахыг хориглоно³⁰.

Хөвийн Хар Тусгай зөвшөөрөлд хамаарах нөөцийн мэдээллийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2010 оны 7-р сарын 14-ний өдрийн ХХ-10-01 тоот дүгнэлтийг үндэслэн АМГ-ын даргын “Зуун Мод Зэс Порфирийн ордын нөөцийг бүртгэх тухай” 2010 оны 7-р сарын 29-ний өдрийн 312 тоот тушаалаар Ашигт малтмалын улсын нөөцийн нэгдсэн бүртгэлд бүртгэсэн байна.

4.8. Хөвийн Хар Тусгай зөвшөөрлийн Техник, эдийн засгийн үндэслэл

Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн ордыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийг хийлгэж тусгай зөвшөөрөл авснаас хойш нэг жилийн дотор (12 дугаар сарын 01-ний өдрийн дотор) холбогдох төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх ёстой байдаг³¹.

Төрийн захиргааны байгууллага нь Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр дүгнэлт гаргуулсны үндсэн дээр Техник, эдийн засгийн үндэслэл, нөөцийн тайлан, мэдээг анхдагч материалын хамт улсын нэгдсэн бүртгэлд бүртгэх эсэх шийдвэрийг гаргадаг³².

²⁸Зөрчлийн тухай хуулийн 7дугаар зүйл 7.15

²⁹Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4

³⁰Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.5

³¹Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.6.1

³²Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4

Бидэнд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн “MV-016836 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөлд хамаарах Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт байрших Зуун Мод молибдэни-зэсийн ордыг ил уурхайн аргаар ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийг хэлэлцсэн тухай” 2013 оны 10-р сарын 09-ний өдрийн 13-15-3 тоот шийдвэрийн хуулбарыг ирүүлсэн бөгөөд тус зөвлөл уг төслийг эдийн засгийн үр ашиггүй гэж үзэж, эдийн засгийн үр ашигтай өөр хувилбарыг тодорхойлж, техник, эдийн засгийн үндэслэлийг дахин боловсруулах нь зүйтэй гэж дүгнэсэн байна.

Техник, эдийн засгийн үндэслэлийг баталгаажуулсан АМГ-ын даргын шийдвэр байхгүй болно.

4.9. Ашигт малтмал ашиглах үйл ажиллагаа эхлэх зөвшөөрөл

Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл нь АМГ-аас томилогдсон комисс уурхайг хүлээж авсны дараа уурхайг ажиллуулж эхлүүлнэ³³. Комисс уурхайг хүлээж аваагүй үед уурхайг ажиллуулж эхлэхийг хориглох бөгөөд үүнийг зөрчсөн тохиолдолд Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээнэ³⁴.

Хөвийн Хар Тусгай зөвшөөрлийн хүрээнд Комисс уурхайг хүлээн аваагүй бөгөөд ашигт малтмал ашиглах үйл ажиллагааг эхлээгүй болохыг АМГ-ын 2018 оны 02 дугаар сарын 08-ний өдрийн 5/1071 тоот Тодорхойлолтоор баталгаажуулсан байна.

4.10. Уулын ажлын төлөвлөгөө, тайлан

Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн жилийн ажлын тайлан болон дараа жилийн уулын ажлын төлөвлөгөөг бэлтгэж жил бүрийн 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор холбогдох байгууллагад ирүүлэх ёстой байдаг ба төлөвлөгөөг хугацаандаа хүргүүлээгүй бол холбогдох албан тушаалтанд Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг³⁵.

Ашиглалтын үйл ажиллагааг эхлүүлээгүй байгаа тул уулын ажлын тайлан болон төлөвлөгөө байхгүй болохыг АМГ-ын 2018 оны 02 дугаар сарын 08-ний өдрийн 5/1071 тоот бичгээр баталгаажуулсан байна. Хэдий тийм боловч АР нь 2011-2016 онуудад ашиглалтын үйл ажиллагааг эхлүүлээгүй байгаа талаарх тайлан, мэдээллээ жил бүр хүргүүлж байсан байна.

³³ Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4

³⁴ “Хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” (=10'000'000 төгрөг), Зөрчлийн тухай хуулийн 7.11 дүгээр зүйлийн 2.1

³⁵ “Хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” (=10'000'000 төгрөг), Зөрчлийн тухай хуулийн 7.11 дүгээр зүйлийн 2.2

4.11. Байгаль орчныг хамгаалах талаарх ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг

Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг агуулсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөг жил бүр боловсруулж, хэрэгжүүлэх ёстой бөгөөд уг төлөвлөгөө болон түүний тайланг холбогдох төрийн захиргааны байгууллагад хүргүүлж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянуулан батлуулж байхаар хуульд заасан байна³⁶.

Бидэнд тусгай зөвшөөрөлүүдээр олгогдсон талбайд хийгдэх байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын төлөвлөгөөний хуулбаруудыг байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргийн биелэлтэд өгсөн эрх бүхий албан тушаалтны дүгнэлтийн хуулбаруудын хамтаар ирүүлсэн.

Хөндий Тусгай зөвшөөрлийн талбайд 2017 онд хийгдэх байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын төлөвлөгөөг Баянхонгор аймгийн Шинэжинст сум, Баян-Өндөр сумын Байгаль орчин, аялал жуулчлалын газар болон Засаг дарга нар баталж, Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Байгаль орчин, аялал жуулчлалын газрын холбогдох албан тушаалтан мөн байгаль орчны хяналтын улсын байцаагч нар тус тус хянасан байдаг. Уг төлөвлөгөөний тайланг Баянхонгор аймгийн Шинэжинст сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч хянаж үзээд ЭМ нь XV-015569 дугаартай тусгай зөвшөөрөлээр олгогдсон Хөндий талбайд байгаль орчинд хор нөлөөтэй үйл ажиллагаа явуулаагүй бөгөөд нөхөн сэргээх ажлыг жилийн төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн болохыг 2017 оны 12-р сарын 06-ны өдрийн 11 тоот Дүгнэлтээрээ баталгаажуулсан байна.

Цэнхэр Номин Тусгай зөвшөөрлийн талбайд 2017 онд хийгдэх байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын төлөвлөгөөг Баянхонгор аймгийн Шинэжинст сум, Баян-Өндөр сумын Байгаль орчин, аялал жуулчлалын газар болон Засаг дарга нар баталж, уг төлөвлөгөөний тайланг Баянхонгор аймгийн Шинэжинст сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч хянасан байна. Шинэжинст сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч ЭМ нь XV-016956 дугаартай тусгай зөвшөөрөлээр олгогдсон Цэнхэр Номин талбайд байгаль орчинд хор нөлөөтэй үйл ажиллагаа явуулаагүй бөгөөд нөхөн сэргээх ажлыг жилийн төлөвлөгөөгөөр төлөвлөгдсөн дагуу хийсэн болохыг 2017 оны 12-р сарын 05-ны өдрийн 12 тоот Дүгнэлтээрээ баталгаажуулсан байна. Баян-Өндөр сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч ЭМ нь XV-016956 дугаартай тусгай зөвшөөрөлээр олгогдсон Цэнхэр Номин талбайд явуулсан хайгуулын ажлаа нөхөн сэргээх төлөвлөгөөний дагуу явуулсан байна гэсэн 05.04.332.01 тоот Дүгнэлтийг 2017 оны 12-р сарын 08-ны өдөр гаргасан байна.

Бургаст Тусгай зөвшөөрлийн талбайн 2017 оны байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын төлөвлөгөөг Говь-Алтай аймгийн Цогт сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч болон мөн сумын Засаг дарга баталсан байна. Говь-Алтай аймгийн Цогт сумын Мэргэжлийн хяналтын газар ЭМ нь XV-017875 дугаартай тусгай зөвшөөрөлээр олгогдсон талбайд үйл ажиллагаа явуулахдаа байгаль орчны

³⁶ Ашигт малтмалын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.5

менежментийн төлөвлөгөөний дагуу хүлээсэн үүргээ биелүүлсэн болохыг 2017 оны 10-р сарын 23-ны өдрийн 1 тоот Дүгнэлтээрээ баталгаажуулсан байна.

Улаан талбайн 2017 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Засаг дарга баталж, мөн сумын Байгаль орчин, аялал жуулчлалын газар болон байгаль орчны хяналтын улсын байцаагч тус тус баталсан байх ба уг төлөвлөгөөний тайланг Баян-Өндөр сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч нар хянасан байна. Шинэжинст сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч ЛЭ нь XV-016057 дугаартай тусгай зөвшөөрөлээр олгогдсон Улаан талбайд 2017 онд байгаль орчинд хор нөлөөтэй үйл ажиллагаа явуулаагүй болохыг 2017 оны 10-р сарын 12-ны өдрийн 06 тоот дүгнэлтээрээ баталгаажуулсан байна. Баян-Өндөр сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч ЛЭ нь XV-016956 дугаартай тусгай зөвшөөрөлээр олгогдсон Улаан талбайд явуулсан хайгуулын ажлаа нөхөн сэргээх төлөвлөгөөний дагуу явуулсан байна гэсэн 05.04.332.02 тоот Дүгнэлтийг 2017 оны 12-р сарын 08-ны өдөр гаргасан байна.

Эдгээр дөрвөн (4) хайгуулын тусгай зөвшөөрөлээр олгогдсон талбай нь Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль болон Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 194 болон 2015 оны 289 дүгээр тогтоолоор тус тус тогтоосон хамгаалалтын бүс болон хориглосон газар, талбайтай давхцаагүй болохыг Байгаль орчин, аялал жуулчлалын яам 2018 оны 2-р сарын 08-ны өдрийн 06а/872 болон 06а/873 тоот Тодорхойлолтоор баталгаажуулсан байна.

4.12. Байгаль орчныг хамгаалах талаар ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх үүрэг

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн дагуу аж ахуйн нэгж, байгууллага нь байгаль орчныг хамгаалах талаар дараах үүргийг хүлээдэг³⁷:

- a) Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, Засгийн газар, нутгийн өөрөө удирдах байгууллага болон Засаг даргын шийдвэр, улсын байцаагч, байгаль хамгаалагчийн шаардлагыг биелүүлэх;
- b) Байгаль орчны холбогдолтой стандарт, хэм хэмжээ, дүрэм, журмыг чанд сахин биелүүлж, дотоодын хяналтыг хэрэгжүүлэх;
- c) Байгаль орчинд гаргаж байгаа хорт бодис, физикийн хортой нөлөөлөл, хог хаягдлын хэмжээг бүртгэж
- d) хорт бодис, хортой нөлөөлөл, хог хаягдлыг багасгах, зогсоох талаар авсан арга хэмжээний талаар тайлагнах.

Ашигт малтмалын тухай хууль болон Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийлгэж, холбогдох төрийн захиргааны байгууллагад хүргүүлж батлуулахаар заасан³⁸.

³⁷ Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31 дүгээр зүйл

³⁸ Ашигт малтмалын тухай хуулийн 25 дүгээр зүйлийн 25.1.7

Түүнчлэн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг агуулсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөг жил бүр боловсруулж, хэрэгжүүлэх ёстой бөгөөд уг төлөвлөгөөг холбогдох захиргааны байгууллагад хүргүүлж батлуулдаг³⁹.

Зуун Мод Молибдэни-зэсийн төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг Байгаль орчин, аялал жуулчлалын яам 2011 онд баталсан байдаг.

АР-ын ашиглалтын тусгай зөвшөөрөлээр олгогдсон талбай нь Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль болон Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 194 болон 2015 оны 289 дүгээр тогтоолоор тус тус тогтоосон хамгаалалтын бүс болон хориглосон газар, талбайтай давхцаагүй болохыг Байгаль орчин, аялал жуулчлалын яам 2018 оны 2-р сарын 08-ны өдрийн 06а/974 тоот Тодорхойлолтоор баталгаажуулсан байна.

Түүнчлэн Байгаль орчин, аялал жуулчлалын яамны архивт АР-аас байгаль орчны менежментийн төлөвлөгөө ирүүлж байсан, байгаль орчныг нөхөн сэргээхэд шаардагдах зардлыг төвлөрүүлж байсан талаар мэдээлэл бүртгэгдээгүй байна.

4.13. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг цуцлах үндэслэл

АМГ нь ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг дараах үндэслэлээр цуцална⁴⁰: Үүнд:

- a) Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Ашигт малтмалын тухай хуульд заасан шаардлагыг хангахгүй болсон;
- b) Тусгай зөвшөөрөл эзэмшигч тусгай зөвшөөрлийн төлбөрийг хугацаанд нь төлөөгүй;
- c) Хайгуулын болон уурхайн талбайг нөөц болон тусгай хэрэгцээнд авч, нөхөх олговрыг тусгай зөвшөөрөл эзэмшигчид бүрэн төлсөн;
- d) Тухайн жилд гүйцэтгэсэн хайгуулын ажлын зардал нь Ашигт малтмалын тухай хуульд заасан хайгуулын ажлын зардлын доод хэмжээнээс бага бол;
- e) Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг нөхөн сэргээх үүргээ биелүүлээгүй талаар нутгийн захиргааны байгууллагын саналыг харгалзан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дүгнэлт гаргасан;
- f) Хайгуулын талбайд соёлын өв байгаа нь тогтоогдсон;
- g) Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн зүйл, заалт болон Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль дагаж мөрдөх журмын тухай хуулийн дагуу байгуулсан гэрээний заалтыг зөрчсөн;
- h) Ашигт малтмалын тухай хуулийг зөрчиж тусгай зөвшөөрлийг шилжүүлсэн;

³⁹ Ашигт малтмалын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.7

⁴⁰ Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйл

- i) Татварын болон улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад холбогдох хуулийн дагуу тайлагнах үүргээ биелүүлээгүй.

Холбогдох эрх бүхий байгууллагын Тодорхойлолтууд болон бидний хянасан баримт бичигт үндэслэн дүгнэхэд ЭРД-ийн Тусгай зөвшөөрлүүдийн хувьд АМГ-аас тусгай зөвшөөрлийг цуцлах аливаа нөхцөл байдал үүсээгүй байна.

4.14. Оюуны өмчийн эрх байхгүй тухай

Бидний мэдэж байгаа хүрээнд болон ЭРД, түүний Монгол компаниудын баталсанаар компаниудын нэр дээр ямар нэг оюуны өмчийн эрх, барааны тэмдэг, патент бүртгэлгүй болно.

ТАВ. ӨМЧЛӨХ ЭРХ

5.1. ЭРД-ийн өмчлөх эрх

2003 оны 11-р сарын 19-ний өдөр үйлдсэн ЭРД-ийн Дүрмийн 47 дугаар зүйлд зааснаар Захирлуудын Зөвлөл нь ЭРД-ийн зарласан боловч эзэмшүүлээгүй хувьцааг бүхэлд нь буюу хэсэгчлэн худалдан авахын тулд тухай бүр опцион хуваарилах буюу гаргаж болно. Иймээс, ЭРД нь хувьцаа эзэмшигчид болон үнэт цаастай холбоотой дараах төлөвлөгөөг баталсан байна.

- ЭРД-ийн Захирлуудын Зөвлөл нь ЭРД-д хувьцааны хяналтын багцыг худалдан авах үнийн санал тавихад хувьцаа эзэмшигчдэд саад учруулах зорилгогүй, хувьцааны хяналтын багцыг худалдан авах санал тавихтай холбогдуулан хувьцаа эзэмшигчдэд шударга хандахын тулд 2008 оны 3-р сарын 14-ний өдөр Хувьцаа эзэмшигчийн эрхийн төлөвлөгөө (Эрхийн төлөвлөгөө) гаргахыг зөвшөөрчээ. Эрхийн төлөвлөгөөг 2008 оны 3-р сарын 28-нд ЭРД-ийн Хувьцаа эзэмшигчдийн жилийн, ээлжит бус хурлаар анх баталсан. ЭРД нь 2017 оны 6-р сарын 14-ний өдөр шинэчилсэн Хувьцаа эзэмшигчийн эрхийн гэрээг (Гэрээ) Эрхийн агент болох Компьютершэйр Инвестор Сервисэс Инк. компанитай байгуулсан ба Эрхийн төлөвлөгөөтэй холбоотой тус Гэрээг 2008 оны 3-р сарын 14-нд байгуулж, 2011 оны 6-р сарын 23 болон 2014 оны 6-р сарын 19-нд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Энэхүү Гэрээний дагуу ЭРД нь эрхийн гэрчилгээ олгох, шилжүүлэх болон солих, эрх хэрэгжүүлэх, Гэрээнд дурдсан бусад асуудлаар түүний нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулах Эрхийн агентийг томилжээ.
- ЭРД нь өөрийн хувьцааг эзэмшихэд захирлууд, ажилтнууд, зөвлөхүүд болон удирдах түвшний ажилтнуудыг дэмжих, ингэснээр тэдний ЭРД-ийн хувьцааг эзэмших сонирхлыг нэмэгдүүлэх, мөн тэднийг ЭРД-д ажиллахыг нь дэмжиж урамшуулах, ажлын гүйцэтгэлтэй холбоотой гаргасан ололт, амжилтыг нь үнэлж урамшуулах болон ажил, үүргээ гүйцэтгэхэд гаргасан хүчин чармайлтыг нь үнэлж ЭРД болон түүний харилцан хамааралтай

этгээдүүдийн өмнөөс нэмэлт урамшуулал үзүүлж ЭРД болон түүний охин компаниудын ашиг сонирхлыг нэмэгдүүлэх зорилгоор Хувьцааны опционы урамшууллын төлөвлөгөөг (Төлөвлөгөө) 2007 оны 4-р сарын 9-нд баталсан. Төлөвлөгөөний дагуу 2019 оны 6-р сарын 14-ний өдөр хүртэл гаргаж хуваарилаагүй опционыг Хувьцаа эзэмшигчид 2016 оны 6-р сарын 14-нд баталжээ.

Төлөвлөгөөг Захирлуудын Зөвлөл удирддаг ба ЭРД-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал нь тогтоол гаргаж баталдаг.

Опцион эзэмшигч нь Төлөвлөгөөний нөхцөлийн дагуу опционыг хэрэгжүүлэх хүртэл тухайн опционд хамаарах аливаа хувьцаатай холбоотойгоор ЭРД-ийн хувьцаа эзэмшигчийн эрх эдэлдэггүй бөгөөд ЭРД Төлөвлөгөөний нөхцөлд зааснаар Опцион эзэмшигчид хувьцааг гаргадаг.

- Ирээдүйд эзэмшүүлэх нэгж хувьцааны төлөвлөгөөг (ИЭНХ Төлөвлөгөө) ТХБ-ээс 2012 оны 11-р сарын 7-ны өдөр зөвшөөрөл авч, 2012 оны 10-р сарын 26-ны өдрийн ЭРД-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар баталсан ба Захирлуудын Зөвлөлийн тогтоолоор 2015 оны 4-р сарын 30-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. ИЭНХ Төлөвлөгөө нь ЭРД-д захирал болон ажилтнаар ажиллах авьяаслаг хувь хүмүүсийг татах, удаан хугацаанд ажиллуулах ЭРД-ийн чадварыг нэмэгдүүлэх, боломжит захирлууд болон ажилтнуудад олгох нөхөн олговрыг Энгийн хувьцааны ирээдүйн үнэ цэнтэй уялдуулж ЭРД-ийн тодорхой тооны захирлууд, ажилтнууд болон хувьцаа эзэмшигчдийн хоорондын ашиг сонирхлыг дэмжиж урамшуулах зорилготой. ИЭНХ Төлөвлөгөөний дагуу ЭРД-ийн захирлууд болон ажилтнууд нь ИЭНХ-д хамаарах жилийн нөхөн олговроо бүхэлд нь эсхүл хэсэгчлэн авахаар шийдэж болно.

Аливаа ИЭНХ-ийн эзэмшигч ямар ч үед ЭРД-ийн хувьцаа эзэмшигчийн эрх эдлэхгүй ба гэрээслэлийн дагуу захиран зарцуулах эсхүл эд хөрөнгө шилжүүлэхтэй холбоотой үйлчилж буй хуульд зааснаас бусдаар ИЭНХ болон ИЭНХ Төлөвлөгөөнд заасны дагуу оролцогчийн ямарваа эрх буюу ашиг сонирхлыг шилжүүлдэггүй.

ЭРД нь 2017 онд өөрийн тодорхой тооны захирлууд болон ажилтнуудад дараах опцион, ИЭНХ-ийг гаргасан байна. Үүнд:

- **Хувьцааны опцион.** 2017 оны 4-р сарын 1-нд 2'620'000 опционыг ЭРД-ийн тодорхой тооны захирлууд болон ажилтнуудад гаргасан. 2022 оны 3-р сарын 31-ний өдрийг хүртэл опцион бүрийг нэгж хувьцаанд 0.87 ам.доллараар хөрвүүлнэ.

2017 оны 9-р сарын 30-ны өдрөөр дуусгавар болсон есөн сарын хугацаанд ЭРД нь нэгж хувьцаанд ойролцоогоор 0.18 ам.долларын дундаж ханшаар 687'500 хувьцаа худалдан авах опционд хөрвүүлсэн 125,975 ам.доллар хүлээн авчээ.

- **ИЭНХ.** 2017 оны 9-р сарын 30-ны өдрөөр дуусгавар болсон есөн сарын хугацаанд ЭРД нь ойролцоогоор 0.86 ам.долларын жигнэсэн дундаж ханшаар нийтдээ 115'123 ИЭНХ-ийг тодорхой тооны захирлууд болон ажилтнууддаа гаргасан байна⁴¹.

2017 оны 12-р сарын 31-ний байдлаар, опцион олгосон ЭРД-ийн захирлууд болон ажилтнуудын жагсаалтыг дараах хүснэгтээс харна уу.

Хүснэгт. ЭРД-ээс опцион олгосон захирлууд болон ажилтнуудын жагсаалт

Опцион эзэмшигчийн нэр	Опционы тоо	Үнэ /ам.доллар/	Тогтоолын огноо	Олгосон өдөр	Дуусах хугацаа
Петер Акерли	400'000	0.87	2017.03.23	2017.04.01	2022.03.31
Виллиам Б. Бартон	100'000	0.87	2017.03.23	2017.04.01	2022.03.31
Жэй.С. (Крис) Кован	100'000	0.87	2017.03.23	2017.04.01	2022.03.31
Кеннет В. МакДоналд	150'000	0.87	2017.03.23	2017.04.01	2022.03.31
Майкл Экс. Гиллис	175'000	0.87	2017.03.23	2017.04.01	2022.03.31
Д. Сюзан Фразер	50'000	0.87	2017.03.23	2017.04.01	2022.03.31
Жон П. Бюрн	100'000	0.87	2017.03.23	2017.04.01	2022.03.31
Баярмаа Багабанди	100'000	0.87	2017.03.23	2017.04.01	2022.03.31
Уламбаяр Ууганбаяр	20'000	0.87	2017.03.23	2017.04.01	2022.03.31
Майк О'Кифе	150'000	0.87	2017.03.23	2017.04.01	2022.03.31
Энхбаатар Ганзориг	25'000	0.87	2017.03.23	2017.04.01	2022.03.31
Давсон Бриско	150'000	0.87	2017.03.23	2017.04.01	2022.03.31
Петер Далтон	75'000	0.87	2017.03.23	2017.04.01	2022.03.31
Филип Вебстер	100'000	0.87	2017.03.23	2017.04.01	2022.03.31
Эрдэнэбилэг Пагва (Билли)	75'000	0.87	2017.03.23	2017.04.01	2022.03.31
Оюунгэрэл Акерли (Шарав)	25'000	0.86	2017.03.23	2017.04.01	2022.03.31
Эрдэнэбаатар Отгонбаатар (Эрка)	40'000	0.87	2017.03.23	2017.04.01	2022.03.31
Бат-Эрдэнэ Гэндэнжамц	75'000	0.87	2017.03.23	2017.04.01	2022.03.31
Жон Лёонс	150'000	**		2017.07.18	2022.07.18
Меган Жеффриес	25'000	0.87	2017.03.23	2017.04.01	2022.03.31
Майк МакДоналд	150'000	0.87	2017.03.23	2017.04.01	2022.03.31
Билгүүн Анхбаяр	150'000	0.87	2017.03.23	2017.04.01	2022.03.31
Лэйтон Крофт	150'000	0.87	2017.03.23	2017.04.01	2022.03.31
Дэвид Мошер	100'000	0.87	2017.03.23	2017.04.01	2022.03.31
Анна Биолик	100'000	0.87	2017.03.23	2017.04.01	2022.03.31
Гансүх Яахүү	15'000	0.87	2017.03.23	2017.04.01	2022.03.31
Бадрах Болор-	20'000	0.87	2017.03.23	2017.04.01	2022.03.31

⁴¹ 2017 оны 9-р сарын 30-ны өдрөөр дууссан улирал тутмын Улирдлагын хэлэлцүүлэг ба дүн шинжилгээ, 13-р хуудас

Канадын дүгнэлтийн дагуу ЭРД-ийн тодорхой тооны захирлууд болон ажилтнуудад опцион олгохдоо ЭРД-ийн зохих шийдвэр, тогтоолд үндэслэсэн бөгөөд опцион эзэмших эрх нь энэхүү Дүгнэлтийг гаргах өдрийн байдлаар хүчин төгөлдөр байна.

2017 оны 12-р сарын 31-ний байдлаар, Скотиабанкны баталгаажуулснаар ЭРД нь тус банкинд бизнесийн үйл ажиллагааны хоёр данс эзэмшдэг.

2017 оны 9-р сарын 30-ний байдлаар ЭРД-д, баталгааны гэрээ, аль нэг этгээдэд шилжүүлсэн хөрөнгөтэй холбоотой нөхцөлт ашиг сонирхол, үүсмэл хэрэгслийн үүрэг, эсхүл ЭРД-д санхүүгийн, хөрвөх чадварын, зах зээлийн буюу зээлийн эрсдэл үүсгэх аливаа үүрэг зэрэг тайлан тэнцэлдээ тусгаагүй тохиролцоо, хэлцэл байхгүй⁴².

Канадын дүгнэлт болон бидний олж авсан мэдээллээр баталгаажуулсны дагуу ЭРД-д түүний нэр дээр бүртгэлтэй томоохон үл хөдлөх болон бусад эд хөрөнгө байхгүй.

5.2. ЭМ-ын өмчлөх эрх

ЭМ нь Баянхонгор аймгийн Шинэжинст суманд Баян Хөндийн кэмп байгуулах зорилгоор 20'000 кв газрыг сумын Засаг даргын 2008 оны 11-р сарын 4-ний өдрийн 63 тоот захирамжийн дагуу 2015 оноос эхлэн 15 жилийн хугацаагаар эзэмшдэг бөгөөд Газар эзэмшүүлэх гэрээг (Гэрээ) 2017 оны 5-р сарын 29-нд байгуулсан. Газар эзэмших эрхийн гэрчилгээг хараахан олгоогүй байна. Гэрээний 2 дугаар зүйлийн 2.3-т зааснаар ЭМ нь газрын төлбөрийг улирал бүрийн эхний сарын 25-ны дотор төлөх бөгөөд 2016, 2017 оны газрын төлбөрийг 2017 оны 6-р сарын 12-нд зохих ёсоор төлсөн байна.

ЭМ нь 2017 оны 8-р сарын 18-ны өдөр байгуулсан Хувьцаа худалдах, худалдан авах гэрээний дагуу ЛЭ-ийн нийт гаргасан болон зарласан энгийн хувьцааны 51 хувийг эзэмшигч юм.

Хувьцаа худалдах, худалдан авах гэрээтэй холбоотойгоор ЛЭ-ийн Хувьцаа эзэмшигчид нь Хувьцаа эзэмшигчдийн тогтоолыг зохих ёсоор гаргасан бөгөөд мөн ЭМ болон ЛЭ нь 2017 оны 8-р сарын 18-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн гэрээг байгуулсан байна. 2017 оны 8-р сарын 23-ны өдөр ЛЭ-ийн улсын бүртгэлийн гэрчилгээнд түүний хувьцаа эзэмшигчдийн мэдээлэлд үйлчилж буй хууль тогтоомжийн дагуу зохих өөрчлөлт оруулсан байна.

ЭМ нь түүний нэрийн өмнөөс Хувьцаа худалдах, худалдан авах гэрээ байгуулах, гарын үсэг зурахыг зөвшөөрч А.Билгүүнд итгэмжлэл олгосон байх ба ЭМ-ын цорын ганц хувьцаа эзэмшигч болох ЭРД нь ЛЭ-ийн нийт гаргасан болон зарласан энгийн хувьцааны 51 хувийг худалдан авах тухай Хувьцаа эзэмшигчийн шийдвэрийг 2017 оны 8-р сарын 16-ны өдөр зохих ёсоор гаргасан байна.

⁴²2017 оны 9-р сарын 30-ны өдрөөр дууссан улирал тутмын Улирдлагын хэлэлцүүлэг ба дүн шинжилгээ, 34-р хуудас

Хувьцаа худалдах, худалдан авах гэрээний 3 дугаар зүйлийн 3.1-д зааснаар, ЭМ-д тус гэрээний болзол, нөхцөлөөр ЛЭ-ийн нийт гаргасан болон зарласан энгийн хувьцааны үлдэж буй 49 хувийг эзэмших онцгой бөгөөд эргэлт буцалтгүй сонголт олгосон ба ЛЭ-ийн нийт гаргасан болон зарласан энгийн хувьцааны үлдэж буй 49 хувийг эзэмшигч З.Эрдэнэчулуун 2017 оны 8-р сарын 18-ны өдөр байгуулсан Хувьцаа барьцаалах гэрээнд үндэслэн ЛЭ-ийн нийт гаргасан болон зарласан энгийн хувьцааны үлдэж буй 49 хувийг ЭМ-д шилжүүлэх үүргийнхээ баталгаа болгож тус 49 хувийн хувьцааг барьцаалсан байна. ЛЭ-ийн нийт гаргасан болон зарласан энгийн хувьцааны үлдэж буй 49 хувийг үүргийн баталгаа болгож барьцаалсан энэхүү үйлдэл нь Иргэний хуульд нийцэж байна.

ЭМ нь Худалдаа Хөгжлийн банкинд ам.долларын 499074745, төгрөгийн 499074734 дугаартай данс эзэмшдэг. Тус банкнаас 2018 оны 1-р сарын 31-ний өдөр гаргасан 7-499ТХТ/050 тоот Тодорхойлолтын дагуу ЭМ нь зээл аваагүй, банкинд өр төлбөргүй байна.

Бидний мэдэж байгаа хүрээнд, мөн ЭМ-ын баталгаажуулснаар, энэхүү Дүгнэлтийг гаргах өдрийн байдлаар ЭМ нэг тал нь болж байгаа эсхүл ЭМ-ын харилцан хамааралтай этгээдүүдтэй холбоотой ямарваа гэрээний дагуу ЭМ нь аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээгээгүй.

5.3. АР-ын өмчлөх эрх

АР нь Баянхонгор аймгийн Шинэжинст суманд Зуун Мод кэмп байгуулах зорилгоор 1'8 га газрыг сумын Засаг даргын 2008 оны 11-р сарын 4-ний өдрийн 63 тоот захирамжийн дагуу 30 жилийн хугацаагаар эзэмшдэг. Газар эзэмшүүлэх гэрээ (Гэрээ)-г 2011 оны 11-р сарын 17-нд байгуулсан ба Газар эзэмших эрхийн 0230777 тоот гэрчилгээг мөн өдөр олгосон байна. Гэрээний 2 дугаар зүйлийн 2.3-т зааснаар АР нь газрын төлбөрийг улирал бүрийн эхний сарын 25-ны дотор төлөх бөгөөд газрын төлбөрийг 2017 оны 6-р сарын 12-нд зохих ёсоор төлсөн байна.

АР нь Худалдаа Хөгжлийн банкинд ам.долларын 499071846, төгрөгийн 499071835 дугаартай данс эзэмшдэг. Тус банкнаас 2018 оны 1-р сарын 31-ний өдөр гаргасан 7-499ТХТ/049 тоот Тодорхойлолтын дагуу АР нь зээл аваагүй, банкинд өр төлбөргүй байна.

Бидний мэдэж байгаа хүрээнд, мөн АР-ын баталгаажуулснаар, энэхүү Дүгнэлтийг гаргах өдрийн байдлаар АР нэг тал нь болж байгаа эсхүл АР-ын харилцан хамааралтай этгээдтэй холбоотой ямарваа гэрээний дагуу АР нь аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээгээгүй.

5.4. ЛЭ-ийн өмчлөх эрх

ЛЭ нь Худалдаа Хөгжлийн банкинд төгрөгийн 411031730 дугаартай данс эзэмшдэг. Тус банкнаас 2018 оны 1-р сарын 31-ний өдөр гаргасан 7-499ТХТ/048 тоот Тодорхойлолтын дагуу ЛЭ нь зээл аваагүй, банкинд өр төлбөргүй байна.

Бидний мэдэж байгаагаар, мөн ЛЭ-ийн баталгаажуулснаар, энэхүү Дүгнэлтийг гаргах өдрийн байдлаар ЛЭ нэг тал нь болж байгаа эсхүл ЛЭ-ийн харилцан хамааралтай этгээдүүдтэй холбоотой ямарваа гэрээний дагуу ЛЭ нь аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээгээгүй.

Хүндэтгэсэн,


Б.Баяр
Гүйцэтгэх захирал


Б.Нямцэрэн
Ахлах хуульч

Хавсралт 1. Канадын дүгнэлт

Хавсралт 2. Танилцсан баримт бичгийн жагсаалт

Хавсралт 3. Төрийн байгууллагаас авсан тодорхойлолтууд

Хавсралт 4. Бүртгэлийн өргөдөл гаргах ажиллагаанд оролцсон этгээдүүдийн тодорхойлолт захидал

Хавсралт 5. ИЭЛСИ-ийн хуульчдын зөвшөөрөл, гэрчилгээ